



**БОЛОВСРОЛЫН
ХҮРЭЭЛЭН**



Боловсролын хүрээлэнгийн захирлын
2019 оны 9 дүгээр сарын 26-д өдрийн
тоот тушаалын гуравдугаар хавсралт

**БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН ЗААВАЛ СУДЛАХ, СОНГОН СУДЛАХ МОНГОЛ ХЭЛ,
ҮНДЭСНИЙ БИЧИГ, УРАН ЗОХИОЛ, МАТЕМАТИК, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ,
ФИЗИК, БИОЛОГИ, ХИМИ, ГАЗАР ЗҮЙ, НИЙГЭМ СУДЛАЛ, АНГЛИ ХЭЛ, ОРОС
ХЭЛНИЙ БОЛОН ЗААВАЛ СУДЛАХ МОНГОЛЫН ТҮҮХ, БИЕЙН ТАМИР, ДИЗАЙН
ЗУРАГ ЗҮЙ, ТЕХНОЛОГИ, СОНГОН СУДЛАХ ТҮҮХ, ДИЗАЙН, ТЕХНОЛОГИЙН
САЙЖРУУЛСАН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ СУРАЛЦАХУЙН УДИРДАМЖ**

(Бүрэн дунд боловсрол X-XII анги)

Улаанбаатар
2019



**БОЛОВСРОЛЫН
ХҮРЭЭЛЭН**

**ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН УРАН
ЗОХИОЛЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
СУРАЛЦАХУЙН УДИРДАМЖ**

**(Бүрэн дунд боловсролын XI анги.
Заавал судлах ба сонгон судлах хөтөлбөр)**

Улаанбаатар
2019

“Монгол хэл бичиг, уран зохиол”-ын сургалтын цөм хөтөлбөр (2016)

Багийн ахлагч:

Ш.Оюунцэцэг

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн Хэл, нийгэм хүмүүнлэгийн ухааны Сургалтын албаны дарга, магистр

Багийн гишүүд

Монгол хэл:

М.Базаррагчаа

Sc.D., профессор, МУИС, Монгол хэлний тэнхимийн багш

Б.Мөнгөнцэцэг

Ph.D., МУИС, Монгол хэлний тэнхимийн багш

Б.Оюунцэцэг

магистр, Боловсролын хүрээлэнгийн ЭША

Ц.Өнөрбаян

Sc.D., профессор, МУБИС, МСТ-ийн эрхлэгч

Ц.Туул

магистр, Шинэ-Эрин сургуулийн багш

Б.Цасанчимэг

магистр, Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн арга зүйч

Ө.Цэндсүрэн

магистр, Нийслэлийн Боловсролын газрын мэргэжилтэн

А.Энхнаран

магистр, Байгаль эх лицей сургуулийн багш

Д.Эрдэнэсан

Ph.D., МУБИС, Монгол хэлний тэнхимийн багш

Уран зохиол:

Г.Галбаяр

Ph.D., дэд профессор, МУИС, Уран зохиолын тэнхимийн

эрхлэгч

Ц.Март

магистр, Нийслэлийн 11 дүгээр сургуулийн монгол хэлний багш

Г.Нандинбилиг

Ph.D., дэд профессор, МУИС, Уран зохиолын тэнхимийн багш

П.Нармандах

Ph.D., МУБИС, УЗ-ын тэнхимийн багш

П.Одсүрэн

Ph.D., Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн арга зүйч

Д.Туяа

Ph.D., Шинэ-Эхлэл сургуулийн багш

С.Энхбаяр

ScD., профессор, МУБИС, УЗСЗ-н тэнхимийн эрхлэгч

Үндэсний бичиг:

Ү.Ариунболд

Ph.D., дэд профессор, МУБИС, Монгол хэлний тэнхимийн багш

Д.Баттогтох

Ph.D., Боловсролын хүрээлэнгийн ЭША

Б.Батчимэг

Нийслэлийн 23 дугаар сургуулийн багш

Н.Мөнхцэцэг

Нийслэлийн 39 дүгээр сургуулийн багш

Д.Соронзон

Ph.D., МУБИС, Монгол хэлний тэнхимийн багш

Хөндлөнгийн шинжээч:

А.Цог-Очир Ph.D., профессор, МУБИС, Монгол хэлний тэнхимийн багш
Ц.Оюун Sc.D., профессор, МУБИС, Монгол хэлний тэнхимийн багш

Сургалтын цөм хөтөлбөрийг сайжруулсан ажлын хэсэг (2019)

Д.Эрдэнэсан Ph.D., МУБИС, Монгол хэлний тэнхимийн багш
А.Энхнаран магистр, Байгаль эх лицей сургуулийн багш
Б.Сүхболд ЕБ-ын 33 дугаар сургуулийн багш
Д.Соронзон Ph.D., МУБИС, Монгол хэлний тэнхимийн багш
Г.Нандинбилиг Ph.D., дэд профессор, МУИС, Уран зохиолын тэнхимийн багш
Ш.Оюунцэцэг магистр, Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн Хэл,
нийгэм хүмүүнлэгийн ухааны Сургалтын албаны дарга
Л.Цэдэнсодном Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

Хянан тохиолдуулсан (2019)

Л.Цэдэнсодном Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

XI АНГИ: УРАН ЗОХИОЛ (ЗААВАЛ СУДЛАХ АГУУЛГА)

Энэхүү бичиг баримт нь бүрэн дунд боловсролын хөтөлбөрийн дагуу 11 дүгээр ангид уран зохиолын хичээлийн сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, удирдаж чиглүүлэх, зааж хэрэгжүүлэх, үнэлгээ дүгнэлт хийхэд нь багш нарт арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилготой зөвлөмж болно.

11 дүгээр ангийн уран зохиолын хичээлийн агуулга нь өрнө дорнын өөр өөр соёлын уянга, туульс, жүжгийн зохиолоос түүх, нийгэм, соёлын олон янз байдлыг тусгаж, хүний эрх, эрх чөлөө, ёс суртахууны суурь үнэт зүйлсийг хамгаалсан утга сэдэвтэй шилдэг зохиолуудыг монгол орчуулгаар уншиж, дэлхийн түүх, нийгэм, соёлын хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэх замаар сурагчид шүүмжлэлт ба бүтээлч сэтгэлгээгээ хөгжүүлэхэд чиглэнэ. Судлах эх зохиолууд нь өрнө дорнын нийгэм соёлын олон янз байдлыг тусгасан, хүний эрх, эрх чөлөө, ёс суртахууны суурь үнэт зүйлсийг хамгаалсан утга сэдэвтэй, цагийн шалгарлыг давж үнэлэгдсэн шилдэг бүтээлүүд байна.

Арга зүйн хувьд, өөр өөр соёлын уран зохиолын хам сэдэв буюу дүрийг тодорхойлж буй цаг үе, нийгэм, соёл, түүх хийгээд шинжлэх ухааны нөлөө, үзэл суртал зэрэг зохиолын хамгийн их мэдээлэлтэй хэсэг дээр төвлөрч хэлэлцэх замаар хүний мөн чанарыг эргэцүүлэхэд чиглэнэ. Уран зохиолын хам сэдэвт судалгааг бид хам сэдэв - уншигч, хам сэдэв - зохиогч, хам сэдэв - бичвэр гэсэн гурван талаас нь авч үзэж, дараах суралцахуйн зорилтуудыг хэрэгжүүлнэ.

Суралцахуйн зорилт	Үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p>11.1а. Өрнө дорнын өөр өөр соёлын уран зохиолоос уншиж, хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэх замаар хүний нийгэм, соёлын олон янз байдлыг ойлгож, дүгнэлт гаргах</p> <ul style="list-style-type: none"> • Их туульс • Өгүүллэг, тууж 	<ul style="list-style-type: none"> - Сурагчдын өмнө нь судалсан өрнө дорно дахины туульс, тууж, өгүүллэгүүдэд зохиолч ямар өвөрмөц онцлогийг бүтээсэн нь ямар үр нөлөөг үзүүлсэн талаар сэргээн ярилцана. - Эх зохиолыг бүрэн эхээр уншина. /Том хэмжээний зохиол бол гэртээ урьдчилан уншсан байна./ - Зохиолын анхны уншлагын дараа өөрийн туршлагаараа дамжуулан, зохиолд гарч байгаа нийгэм, соёл, дүрүүдийг та хэрхэн төсөөлж байгаа, энэ нь танд ямар мэдрэмж төрүүлсэн талаар сэтгэгдлээ хуваалцана. - Зохиолд тэдний нийгэм соёлын ямар онцлог хэлэлцүүлэг туссан байгаа нь танд юуг бодогдуулж байгаа талаар ярилцана. - Уншсан зохиолд гарч байгаа ямар нэгэн үзэл суртал юм уу хэлэлцүүлгийн хүрээнд хүрээнд уншигч өөрийн туршлагаа хуваалцана. - Тухайн зохиолд дэвшүүлсэн хам сэдвийн хүрээнд ямар зонхилох ба зөвшилцөх байр суурь байдаг талаар ярилцана. - Тухайн зохиолд дэвшүүлсэн хам сэдвийн хүрээнд өөрөө ямар үзэл бодол, байр суурьтай байгаагаа хуваалцана. 	<p>А. Судлах эх зохиол</p> <ol style="list-style-type: none"> 1. “Махабхарата” тууль 2. “Игорийн хорооны үг” 3. Нарангэрэл дагины тууж 4. О.Бальзак “Эцэг Горио” тууж 5. А.Доде “Сүүлчийн хичээл” өгүүллэг 6. А.П.Чехов “Хамелеон” өгүүллэг <p>Б. Орчуулгын эх сурвалж</p> <ol style="list-style-type: none"> 1. Махабхарата. Орчуулсан Б.Баясгалан. УБ., 2010 2. Хөвсгөл С, Энхбаяр С. Өрнө дахины уран зохиолын дээж бичиг. 1-р боть УБ., 2010 3. О.Бальзак “Эцэг Горио” тууж-

		<p>Дэлхийн сонгодог утга зохиолын чуулган 50 боть. ред Г.Аким. УБ., 2009</p> <p>4. Дэлхийн сонгомол өгүүллэг. Эрхэлсэн Г.Аюурзана, редактор Л.Өлзийтөгс. УБ., 2010</p> <p>5. Нобелийн шагналт өгүүллэг. Орчуулсан Ц.Цэнгэл. Соёмбо прессХГ., 2015</p> <p>6. Франц зохиолчдын бүтээлээс. Эмхэтгэсэн Б.Алтангүл, УБ, 2005</p>
<p>11.1а. Өрнө, дорнын өөр өөр соёлын уянгын яруу найргаас уншиж, хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэх замаар хүний нийгэм, соёлын олон янз байдлыг ойлгох</p> <ul style="list-style-type: none"> • Хайку, рубай, сонет • Найраглал 	<ul style="list-style-type: none"> - Сурагчдын өмнө нь судалсан өрнө дорно дахины ямар яруу найрагт зохиолч ямар өвөрмөц дүр дүрслэлийг бүтээсэн нь ямар сэтгэгдэл үлдээсэн талаар сэргээн ярилцана. - Өрнө дорнын өөр өөр соёлын сонгодог яруу найргаас хайку, рубай, сонет зэрэг тогтсон хэлбэрийн шүлгүүдээс уншина. - Яруу найргийн дүр дүрслэлийг төсөөлөн мэдрэмжээ илэрхийлнэ. Тухайлбал, юу харснаа, хараад юуг мэдэрснээ гэх мэт \юуг сонссоноо, юунд хүрэлцэж, юуг амтлах мэт болсноо\ - Тэдгээр найрагчдын амьдарч байсан нийгэм, цаг үе хийгээд уншсан шүлгүүдэд цаг үе, нийгэм, хувь хүний сэтгэл зүй хэрхэн туссан талаар ярилцан, сэтгэгдлээ илэрхийлнэ. - Шүлэг, найраглалд үзүүлсэн уянгын баатрын сэтгэл санааны байдлыг хувийн туршлагатай харьцуулан ярилцана. - Дорно хийгээд өрнө дахины дээрх шүлгүүдэд туссан хам сэдвийн хүрэнд үзэл бодлоо илэрхийлнэ. 	<p>А. Судлах эх зохиол</p> <ol style="list-style-type: none"> 1. М.Баше.Хайку 2. О.Хайям. Рубай 3. Ф.Петрарка. Сонет 4. Галидаас. "Үүлэн зардас" найраглал <p>Б. Санал болгох эх сурвалж</p> <ol style="list-style-type: none"> 1. Шри Галидас "Үүлэн зардас- Орчуулсан Б.Ринчен, УБ., 1964 1. Дэлхийн сонгомол яруу найраг. Сонгон түүвэрлэж орчуулсан Г.Аюурзана, редактор Л.Өлзийтөгс. УБ., 2008 2. Дэлхийн сонгодог утга зохиолын чуулган: Дэлхийн яруу найргийн охь

		<p>дээжис. Англи, орос хэлнээс орчуулсан Г.Аюурзана. Ерөнхий редактор Г.Аким. Монсудар. УБ., 2009</p> <p>3. Дэлхийн шилдэг яруу найраг I-IV. Ерөнхий редактор Г.Мэнд-Ооёо.УБ., 2005</p>
<p>11.1а. Өрнө, дорнын өөр өөр соёлын жүжгийн зохиолоос уншиж, хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэх замаар хүний нийгэм, соёлын олон янз байдлыг ойлгох</p>	<ol style="list-style-type: none"> 1. Сурагчдын өмнө нь судалсан өрнө дорно дахины ямар жүжигт зохиолч ямар зөрчлийг бүтээсэн нь ямар сэтгэгдэл үлдээсэн талаар сэргээн ярилцана. 2. Жүжгийн уншаад, дүрийн зан төрх, зохиолын үйл явдлаас төрсөн сэтгэгдэл, сэтгэлийн олон өнгө аясаа илэрхийлнэ. Тухайлбал, айх, догдлох, сандрах, баясах, инээх, гуних, өрөвдөх гэх мэт 3. Жүжгийн үйл явдалд оролцож байна гэж төсөөлөн мэдрэмжээ илэрхийлнэ. Тухайлбал, юу харснаа, хараад юуг мэдрэснээ гэх мэт \юуг сонссоноо, юунд хүрэлцэж, юуг амтлах мэт болсноо\ 4. Жүжигт нийгэм, соёл, түүхийн ямар асуудал хөндсөнийг жишээгээр тайлбарлан ярилцана. 5. Жүжигт дэвшүүлсэн асуудалд өөрийн зүгээс ямар байр суурьтай байгаагаа илэрхийлэн, үзэл бодлоо хуваалцана. 	<p>А. Судлах эх зохиол</p> <ol style="list-style-type: none"> 1. Софокл “Эдип хаан” эмгэнэлт жүжиг <p>Б. Орчуулгын эх сурвалж</p> <ol style="list-style-type: none"> 1. Софокл “Эдип хаан”. Орчуулсан Э.Оюун, УБ., 1979
<p>11.1б. Зохиолын сэдэв, утга санаа, хам сэдвийн холбоо хамаарлаар далд утгыг тайлан тайлбарлах</p>	<ol style="list-style-type: none"> 1. Энэ сэдвээр өөр ямар орны зохиолчид ямар зохиол бичиж, ямар утга санааг бүтээсэн байдаг хийгээд энэ сэдэв хэр нийтлэг сэдэв болох талаар сэргээн санана. 2. Тус зохиолд аль цаг үеийн, ямар онцлог соёлыг тусган үзүүлсэн хийгээд зохиолч ямар сэдвээр бичиж, ямар ялгаатай утга санааг бүтээсэн болохыг тодруулна. 3. Зохиолын бичвэрт гарсан үзэл бодол болон үнэт зүйлсийг тодорхойлж, зохиолд үгээр “хэлсэн” утга санааг тайлбарлах замаар зохиолын утга санааг бодитойгоор хүлээн авна. 4. Зохиолыг туурвихад нөлөөлсөн нийгэм, соёл, түүхийн хам нөхцөлийн талаар цахим сүлжээнээс мэдээлэл цуглуулна. 5. Зохиолд ямар нэгэн нийгмийн үзэл суртлыг үзүүлсэн байна уу, эсвэл соёлын онцлогтой хэлэлцүүлгийг тусгасан байна уу гэдэгт төвлөрч ярилцана. 6. Хэрвээ зохиолд ядуу нэгний хүнд бэрх амьдралыг тусган үзүүлсэн байвал зохиолд энэ нь тухайн хүний залхуу хойрго зангаас болж байна уу, тухайн нийгмийн хүчин зүйлсээс шалтгаалж байна уу, аль эсвэл дайны онцгой нөхцөл байдлаас хамаатай байв уу гэх мэт олон талаас хэлэлцэнэ. 7. Зохиогч ба зохиолын хам сэдэв хоорондын холбоо хамаарлыг судлахдаа бичвэрт юу гэж хэлж, бас юу гэж хэлэхгүй байгааг тогтож шинжилнэ. 8. Уншсан зохиолын далд санааг тайлан тайлбарлахдаа уншсан зохиолын дотор ямар 	<ul style="list-style-type: none"> • М.Баше.Хайку • О.Хайям. Рубай • Ф.Петрарка. Сонет • Галидаас. “Үүлэн зардас” найраглал • “Игорийн хорооны үг” • Нарангэрэл дагины тууж • А.Доде “Сүүлчийн хичээл” өгүүллэг • А.П.Чехов “Хамелеон” өгүүллэг • Софокл “Эдип хаан” эмгэнэлт жүжиг

	<p>зонхилох ба зөвшилцөх байр суурь байгааг тодруулна.</p> <p>9. Уншсан зохиолын бичвэрт гарсан үзэл бодол болон үнэт зүйлсийн талаар зохиолд “үгээр үл хэлсэн” далд санааг тайлан тайлбарлах, харьцуулах замаар өөрийн бодол эргэцүүлэлтэй уншигч болж буйгаа харуулна.</p>	
<p>11.1в. Зохиолын өгүүлэгдэхүүн ба зохиомжийн нэгжүүдийн уялдаа холбоог таньж, утга санаанд хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлох</p>	<ol style="list-style-type: none"> 1. Юуны өмнө зохиолд ямар нэгэн хэрэг явдлыг үзүүлж байна уу, эсвэл хүний сэтгэлийг үзүүлж байна уу гэдгийг тодруулна. 2. Зохиолд хэрвээ хэрэг явдлыг үзүүлж байвал хэрэг явдал хэрхэн эхэлж, өрнөж, туйл, тайлалдаа хүрсэн замын зургийг гаргана 3. Их туульс хийгээд роман, тууж, өгүүллэгт ямар хугацаанд болж буй хэрэг явдлыг тус тус дүрслэн үзүүлэхэд тохиромжтой талаар мэдлэг ойлголтоо хуваалцана. 4. Хүүрнэл, байгалийн зураглал, зүүд, харилцан яриа, дотоод яриа, үглэл яриа, зохиолчийн тэмдэглэл, эргэцүүлэмж, дурсамж, өчил, хөрөг гэх мэт зохиомжийн нэгжүүдээс уншсан зохиолд хэрэглэсэн эсэхийг ялган тэмдэглэнэ 5. Зохиол дахь зохиомжийн нэгжийн хэрэглээг тодруулж, цагийг ухраах буюу урагшлуулахад хэрхэн оролцож байгааг шинжилнэ. 6. Зохиолын хүүрнэн өгүүлэгч нь хэддүгээр биеэс өгүүлж байгаа тухай болон тэрээр бидэнд юуг хэлж, юуг “үл хэлсэн” талаар ярилцан, хүүрнэлийн дуу хоолойг шинжилнэ. 7. Эртний туульсаас орчин үеийн өгүүллэг, туужийн зохиомж хэрхэн ялгарч байгаа талаар тодруулна. 8. Хэрвээ жүжгийн зохиол судалж буй бол харилцан яриа хийгээд үглэл яриа, найрал дууны зохиомжийн үүргийг тодорхойлж, эдгээр нь зохиолын утга санаанд хэрхэн нөлөөлж буйг тайлбарлана. 	<ul style="list-style-type: none"> • “Игорийн хорооны үг” • Нарангэрэл дагинын тууж • А.Доде “Сүүлчийн хичээл” өгүүллэг • А.П.Чехов “Хамелеон” өгүүллэг • Софокл “Эдип хаан” эмгэнэлт жүжиг
<p>11.1г. Зохиолын дүрийн бодгаль ба нийтлэг шинж нь утга санаанд хэрхэн нөлөөлж буйг тодорхойлох</p>	<ol style="list-style-type: none"> 1. Зохиолын дүр нь зан төрхийн өвөрмөц чанараараа ялгарч байна уу, эсвэл нийгмийн бүлгийг төлөөлсөн нийтлэг чанарыг үзүүлж байна уу гэдгийг тодруулна 2. Үүнээс үндэслээд дүр нь бодгаль шинжтэй байна уу, нийтлэг шинжтэй байна уу гэдгийг тодорхойлно. 3. Дүрийн зорилго, зан төрх, үзэл бодол нь тууштай байна уу? Аль эсвэл хувирч өөрчлөгдөж байна уу гэдгийг хэлэлцэх замаар дүр нь зохиолын утгатай хэрхэн холбогдож байгааг тайлбарлана. 4. Дүрийн зан чанар, үйл хэрэг нь зохиолын эхнээс аваад төгсгөл хүртэл яаж өөрчлөгдсөнийг ажиглах, үйл явдлын шугамын дагуу оюуны зураглалын аргаар бүтээж ярилцана 5. Бусдаас ялгарах өөрийн гэсэн давтагдашгүй зан чанартай бодгаль дүрийг ялган, яагаад бодгаль шинжтэй гэж үзсэнээ жишээ баримт татан тайлбарлана 6. Зохиолд дүрийн сэтгэл зүйг нээн харуулсан уу? Дүрийн үзэл санааны зөрчлийг үзүүлсэн үү гэдгийг ярилцаж, энэ нь зохиолын утгыг хэрхэн тодруулж байгаад дүн шинжилгээ хийнэ. 7. Жүжгийн зохиол судалж байгаа бол дүрийн хувь заяаг тэнгэр бурхан шийдэж байна уу, дүр өөрийн шийдвэрийг баталж байна уу гэдгийг онцлон 	<ul style="list-style-type: none"> • Галидаас. “Үүлэн зардас” найраглал • “Игорийн хорооны үг” • Нарангэрэл дагинын тууж • А.Доде “Сүүлчийн хичээл” өгүүллэг • А.П.Чехов “Хамелеон” өгүүллэг • Софокл “Эдип хаан” эмгэнэлт жүжиг

	<p>анхаарч, энэ нь тухайн жүжгийн сэдэв, утгыг хэрхэн тодруулж байгааг тайлбарлана.</p> <p>8. Уянгын яруу найраг судалж байгаа бол өрнө дорны шүлгүүд дэх уянгын баатрын сэтгэлийн илэрхийллийг эргэцүүлж, тухайн шүлгийн сэдэв, утгыг хэрхэн тодруулж байгааг тайлбарлана.</p>	
<p>11.1д. Зохиолын гадаад ба дотоод орчныг задлан шинжилж, дүр ба сэдвийг тодруулахад хэрхэн нөлөөж байгааг тодорхойлох</p>	<ol style="list-style-type: none"> 1. Зохиолын хэрэг явдал хаана болж байгааг тодруулахдаа тодорхой бодитой нэр устай газар орон дүрслэгдэж байна уу, аль эсвэл хийсвэр ерөнхий орон байна уу гэдгийг тодорхойлно 2. Улмаар зохиолд үзүүлсэн цаг хугацааг шинжлэхдээ тодорхой түүхэн он, цаг үе дүрслэгдэж байна уу, аль эсвэл хийсвэр ерөнхий цаг байна уу гэдгийг таньж, тайлбарлана. 3. Зохиолч дүр хийгээд орчныг таниулахдаа хүрээлэн буй орчны үзэгдэл юмс, нарийн ширийн зүйлсийг хэрхэн үзүүлснээр дүрийн талаар чухам юуг хэлж мэдээлж байгааг тодруулна. 4. Зохиолч юмс болоод дүрүүдийн харилцааг үзүүлэхдээ хүний таван мэдрэхүйгээс чухам алийг нь онцолж, түүнд өртөх өнгө, дуу, үнэр, амтыг хэрхэн дүрсэлж, ямар уур амьсгалыг бүтээсэн байгааг тайлбарлана 5. Дүрийн өсөлт төлөвшилд өөрийнх нь үзэл бодол, хүсэл тэмүүлэл нөлөөлөхийн зэрэгцээ гадаад орчин яаж нөлөөлж байгааг харгалзан, зохиолд ёс суртахууны суурь үнэт зүйлсийг хамгаалж байгааг ярилцана. 6. Дотоод орчин буюу ямар дүрүүд ямар нөхцөл байдлыг үүсгэж байгааг, ямар нөхцөл байдалд орсныг тодруулан ярилцах 7. Нөхцөл байдал нь дүрийн зан чанарыг, зорилго, үйл хэргийг хэрхэн өөрчилж байгааг судлах, жишээ татан тайлбарлана. 8. Дотоод орчин болон уур амьсгал нь зохиолын утгад хэрхэн нөлөөлж байгааг тодруулан дүгнэнэ 	<ul style="list-style-type: none"> • М.Баше.Хайку • О.Хайям. Рубай • Ф.Петрарка. Сонет • Галидаас. “Үүлэн зардас” найраглал • “Игорийн хорооны үг” • Нарангэрэл дагины тууж • А.Доде “Сүүлчийн хичээл” өгүүллэг • А.П.Чехов “Хамелеон” өгүүллэг • Софокл “Эдип хаан” эмгэнэлт жүжиг
<p>11.1ж. Зохиолын хэл найруулга, уран дүрслэл, яруу хэрэглүүр, бичил дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөг задлан шинжлэх</p>	<ol style="list-style-type: none"> 1. Уншсан зохиолд дэвшүүлсэн асуудал хийгээд сэдэв утгыг тодорхойлж, үндэслэлтэй тайлбарлана. 2. Зохиолоос утга шилжүүлэн дүрсэлсэн үг хэллэгийг онцолж, үндсэн утгаас шилжсэн ямар утга гарч байгааг ажиглана. 3. Уран дүрслэлүүд нь зохиолын утгад хэрхэн нөлөөлж байгааг ярилцана. 4. Зохиолч дүрийн зан төрхийг тодруулахын тулд ямар үг хэллэг сонгон хэрэглэснийг ажиглаж, үг сонголт нь уншигчдад тухайн дүрийн тухай ямар бодомж, нөлөө үзүүлж буй талаар ярилцана. 5. Зохиолын хэл яриаг илүү үр дүнтэй болгохын тулд хэрэглэсэн яруу хэрэглүүрийг таньж, шинжилнэ. 6. Мөн зохиолд ямар нэгэн цэг тэмдгээр утга илэрхийлэхийг зорьсон туршилт байгаа эсэхийг ажиглан ярилцана. 	<ul style="list-style-type: none"> • М.Баше.Хайку • О.Хайям. Рубай • Ф.Петрарка. Сонет • Галидаас. “Үүлэн зардас” найраглал • “Игорийн хорооны үг” • Нарангэрэл дагины тууж • А.Доде “Сүүлчийн хичээл” өгүүллэг • А.П.Чехов “Хамелеон” өгүүллэг

	<p>7. Яруу найраг уншиж буй бол үг давталтаас эхлээд толгой, сүүл холбоцыг ажиглаж, уншигчийн сэтгэлд нөлөөлөхийн тулд яаж байгуулсныг шинжлэн дүгнэнэ.</p> <p>8. Эцэст нь зохиолчийн сонгосон найруулга нь зохиолын утга санааг тодруулахад хэрхэн нөлөөлсөн талаар дүгнэнэ</p> <p>9. Өрнө дорнын зохиолын төрөл зүйлийг ажиглан, уран зохиолын уламжлалт болон чөлөөт хэлбэрийн талаар төсөөлөл ойлголтоо хуваалцана.</p>	<ul style="list-style-type: none"> • Софокл “Эдип хаан” эмгэнэлт жүжиг •
--	---	--

БИЧИХ

Суралцахуйн зорилт	Үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p>11.2а. Зохиолын утга, бүтцийн онцлогийг задлан шинжилж бичихдээ холбогдох нэр томъёог хэрэглэх</p>	<ol style="list-style-type: none"> 1. Зохиолын сэдэв, утгыг задлан шинжилж тайлбарлан бичнэ. 2. Зохиолын сэдэв, утгыг тодруулахад найруулгын үүргийг шинжилнэ. Орчуулгын хэлээс бичил дүрслэлийн хэрэглээг шинжлэх ямар боломж байна уу гэдгийг шинжилнэ. 3. Уншсан зохиолын найруулгын онцлогийг шинжлэхдээ зохиолд дан ганц түүхийг хүүрнэн өгүүлж байна уу? Эсвэл бас дүрслэн үзүүлж байна уу гэдгийг шинжлэн тодорхойлж бичнэ. 4. Зохиолд ямар нэгэн айзам хэмнэл, эгшиглэлийг бүтээх гэсэн оролдлого байна уу гэдгийг шинжилнэ. 5. Зохиолч дүр хийгээд орчныг үзүүлэхдээ нарийн ширийн зүйлийг орхилгүй, бүхий л талаас нь судлан бичсэн байвал эшлэл авч батална. 6. Ямар нэгэн эгэл жирийн дасал болсон зүйлийг ер бусын сонин хачин болгож дүрслэн үзүүлсэн байвал зохиолын утгыг тодруулж буй нөлөөллийг тайлбарлана. 7. Зохиолын онцлогийг задлан шинжилж бичихдээ уран зохиолын онол түүхийн судалгааны номуудаас уншиж суралцана. 8. Зохиолын утга бүтцийг задлан шинжилж бичихдээ нэр томъёог оновчтой хэрэглэсэн эсэхээ шалгана. 	<ul style="list-style-type: none"> • М.Баше.Хайку • О.Хайям. Рубай • Ф.Петрарка. Сонет • А.П.Чехов “Хамелеон” өгүүллэг • Софокл “Эдип хаан” эмгэнэлт жүжиг <ol style="list-style-type: none"> 1. Энхбаяр С. Утга зохиолын онол. УБ., 2005 2. Хөвсгөл С. Өрнө дахины уран зохиол. (Түүхэн найрууллууд), УБ 2013 3. Хөвсгөл С. Дорно дахины уран зохиол. (Түүхэн найрууллууд), УБ 2014 4. Нандинбилиг Г. Яруу найргийг задлан шинжилж сургахуй. Редактор Д.Нямдорж, МУИС-ПРЕСС, УБ., 2013
<p>11.2б. Өрнө дорнын яруу найргийн хэлбэр бүтцийг дуурайн, тодорхой сэдвийн хүрээнд санаагаа хөгжүүлэн, дүрслэн зохиох</p>	<ol style="list-style-type: none"> 1. Уншсан шүлгийн хэлбэр бүтцийг дуурайн шүлэглэн зохиохын тулд сэдэв хийгээд шүлгийн тогтсон хэлбэрээс сонгоно. 2. Сонгосон хэлбэрийн хүрээнд шад, бадгийг зохион байгуулж, үг хийгээд үеийн тоог төлөвлөнө. 3. Сонгосон сэдвийн хүрээнд дүр дүрслэлийг хэрхэн бүтээж, уншигчийн мэдрэмж хийгээд сэтгэлийг хэрхэн дагуулахаа төлөвлөнө. 4. Төлөвлөсний дагуу шүлгийг эхлэн бичихдээ орон, цаг хийгээд дүрийн тохиргоог хийнэ. 5. Шүлгийн орон, цагийг тохируулахдаа байгалийн зураглалыг ашиглана. 6. Сонгосон сэдвийн хүрээнд уянгын баатрын сэтгэл хөдлөлийг бүтээнэ. 	<ol style="list-style-type: none"> 1. М.Баше. Хайку 2. О.Хайям. Рубай 3. Ф.Петрарка. Сонет

	<p>7. Дүр дүрслэлийг бүтээхдээ уншигчид нөлөөлөхийн тулд уран дүрслэлийн аргаас тохирох байдлаар туршин хэрэглэнэ.</p> <p>8. Уянгын баатрын сэтгэл хөдлөлийг илүү амьдлаг болгохын тулд үгсийг оновчтой сонгосон эсэхээ шалгана.</p> <p>9. Шүлгийн санааг тодруулахын тулд уран дүрслэл, яруу хэрэглүүрийг оновчтой хэрэглэсэн эсэхээ шалгана.</p> <p>10. Шүлгийн санааг төгсгөж буй сүүлийн шадыг сонирхолтой төгсгөсөн эсэхээ шалгана.</p> <p>11. Шүлэгт дэвшүүлсэн санааг дэмжихийн тулд сонгосон хэл хийгээд хэлбэр бүтцийн сонголт оновчтой болсон эсэхийг бусдад уншина.</p> <p>12. Зохиосон шүлгээ бүтээлийн сандаа хийж, багшдаа шалгуулна.</p>	
--	---	--

ЯРИХ-СОНСОХ

Суралцахуйн зорилт	Үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p>11.3а. Уншсан зохиолын хам сэдвийн хүрээнд үзэл бодлоо илэрхийлэн хэлэлцэх</p>	<ol style="list-style-type: none"> Уншсан зохиолын хам сэдвийн талаар дүгнэн бичнэ Тус зохиолд тухайн хам сэдвийг үзүүлэхдээ сэдэв, өгүүлэгдэхүүн, дүр, орчныг хэрхэн ялгаатай сонгон үзүүлсэн нь ямар өвөрмөц онцлогийг бүтээсэн талаар жишээ баримтад тулгуурлан тайлбарлаж бичнэ. Зохиол дахь соёлын ялгаатай байр суурийг эргэцүүлнэ. Уншсан зохиолоос хам сэдвийн хувьд төсөөтэй ч харах өнцгийн хувьд ялгаатай өөр өөр соёлын зохиолыг сонгож, зохиолд үзүүлсэн үзэл суртал юм уу хэлэлцүүлсэн асуудлын талаар харьцуулан эргэцүүлнэ. Тухайн зохиолын төрөл зүйлийн онцлогийг тодорхойлж, уншсан зохиолд үзүүлсэн үзэл суртал юм уу хэлэлцүүлгийн хүрээнд өөрийн байр суурийг илэрхийлэн бичнэ. Судалсан зохиолууд нь тухайн хам сэдвийг үзүүлэхдээ сэдэв, өгүүлэгдэхүүн, дүр, орчныг хэрхэн ялгаатай сонгон үзүүлсэн нь ямар өвөрмөц онцлогийг бүтээсэн талаар жишээ баримтад тулгуурлан хэлэлцэнэ. 	<ul style="list-style-type: none"> М.Баше.Хайку О.Хайям. Рубай Ф.Петрарка. Сонет Галидаас. “Үүлэн зардас” найраглал “Игорийн хорооны үг” Нарангэрэл дагины тууж А.Доде “Сүүлчийн хичээл” өгүүллэг А.П.Чехов “Хамелеон” өгүүллэг Софокл “Эдип хаан” эмгэнэлт жүжиг

ХІ АНГИ: УРАН ЗОХИОЛ
(СОНГОН ГҮНЗГИЙРҮҮЛЭХ)

УНШИХ

Английн уран зохиол: В.Шекспирийн эмгэнэлт жүжгээс уншиж судлах

Суралцахуйн зорилт	Үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p>11.1а. Шекспирийн сонгодог жүжгийн зохиолоос уншиж, хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэх</p>	<p>Уран зохиолын заавал судлах цагаар эртний Грекийн зохиолч Софоклын “Эдип хаан” эмгэнэлт жүжгийн агуулга, уран сайхны онцлогийг тодруулан задлан шинжлэн, өөрийн үзэл бодлоор дүгнэлт өгч сурсан гэж үзнэ. Харин сонгоны цагаар “Гамлет” хэмээх дэлхийн сонгодог зохиолыг уншаад, уран зохиолын хичээлээр эзэмших чадварыг улам хөгжүүлж, задлан шинжилнэ.</p> <p>Хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэхдээ:</p> <ul style="list-style-type: none"> - Жүжигт нийгэм, соёл, түүх, шашин, улс төрийн ямар сэдэв хөндөгдөж байгааг тунгаан бодож унших - Нийгмийн \соёлын, түүхийн, шашны, улс төрийн гм\ ямар асуудал хөндсөнийг жишээгээр тайлбарлан ярих, хэлэлцэх - Тухайн хөндөгдсөн асуудалд өөрийн зүгээс юу гэж дүгнэн эргэцүүлснээ илэрхийлэх <p><i>Багшид зөвлөх нь:</i> <i>Дараах мэдээллийг сурагчдаар уншуулж, нийгмийн болон соёл, улс төр, шашны хам сэдвийн тухай ярилцаж болно. Хам сэдэв гэдэгт түүх, нийгэм, улс төр, соёл, шашин, угсаатны зүй гээд нийгмийн ухамсрын шинжтэй, өргөн хүрээний агуулга бүхий сэдвүүд хамаарна. Практикаас харахад эхийн сэдэв гэдэг ойлголтыг хам сэдэв гэх ойлголттой андуурч, нэг зүйл гэж үзээд зохиолыг задлах хандлага илэрч байна. Үүнд багш нар анхаарах нь зүй. Тусган эргэцүүлэх чадварыг үнэлэхдээ дараах шалгуурыг баримтална.</i></p> <ul style="list-style-type: none"> • <i>Нийгэм, соёл, түүх, шашин, улс төрийн ямар сэдэв хөндөгдөж байгааг ялган харж, бүдүүвч зургаар илэрхийлж байвал</i> • <i>Нийгмийн \соёлын, түүхийн, шашны, улс төрийн гм\ ямар асуудал хөндсөнийг жишээгээр тайлбарлан ярьж байвал, татсан жишээ баримт нь оновчтой байвал</i> • <i>Нийгмийн \соёлын, түүхийн, шашны, улс төрийн гм\ ямар асуудал хөндсөнийг хэлэлцэхдээ бусдын үзэл бодлыг сонсож, хүлээцтэй хандаж байвал</i> • <i>Хэлэлцэхдээ бусдад санаа бодлоо ойлгомжтой илэрхийлж байвал</i> • <i>Хэлэлцэхдээ жишээ баримтыг оновчтой татаж байвал</i> 	<p>В.Шекспирийн эмгэнэлт жүжиг “Гамлет ба Данийн хунтайж”</p>
<p>11.1в. Жүжгийн зохиолын бүтэц, бүрэлдэхүүн хэсгийн холбоо хамаарлыг</p>	<p>А. Бүтэц, бүрэлдэхүүн хэсгийн холбоо хамаарлыг шинжлэхдээ:</p> <ul style="list-style-type: none"> - Жүжгийн найрал дууны хэсэг, ремарк, зохиолчийн тайлбар, харилцан яриа, өчил яриа зэргийг ялган таних - Харилцан ярианаас дүрүүдийн ямар зөрчил илэрч байгааг шинжлэх - Өчил ярианаас дүрийн ямар зан чанар, сэтгэл зүйн онцлог, хүсэл зорилго тодорч байгааг шинжлэх, дүгнэх - Ремаркын дотоод бүтцийг судлан, ямар үүргээр, ямар дүрийг ямар зорилгоор тодруулсныг шинжлэх 	<ul style="list-style-type: none"> • Цахим орчин. Сурагч янз бүрийн сайтаас өөрийнхөөрөө мэдээлэл цуглуулна. • Театр судлаач, театрын найруулагч, утга зохиол судлаач

<p>шинжлэн тайлбарлах</p>	<p>- Зохиолчийн тайлбарын үүрэг, зориулалтыг шинжлэх, дүгнэх</p> <p>Б. Бүтэц, бүрэлдэхүүн хэсгийн холбоо хамаарлыг тайлбарлахдаа:</p> <p>- Жүжгийн найрал дууны хэсэг, ремарк, зохиолчийн тайлбар, үзэгдэл, харилцан яриа, өчил ярианууд нь ямар дарааллаар, яаж холбогдож байгааг жишээ баримт татан тайлбарлах</p> <p>Багшид зөвлөх нь:</p> <p><i>Эмгэнэлт жүжгийг задлан шинжлэхдээ заавал судлах хичээлээр олж авсан мэдлэг ойлголтгоо бататган, эмгэнэлт жүжгийн төрлийн тухай онолын ойлголтыг багш сурагчидтай хамт сэргээн санах зүйтэй.</i></p> <p><i>Жүжгийн зохиол нь дараах бүтэцтэй байна. Эхлэл, найрал дуу, ремарк, зохиолчийн тайлбар, харилцан яриа, өчил зэрэг орно. Ремарк - Баатруудын үйл хөдлөл, дохио зангаа, нүүрний хувирал, өөрчлөлт, дууны өнгө, хэлсэн үгийн сэтгэлзүйн утга, ярианы хурд, үйл явдлын байр байдал, завсарлага зэрэг орно. Харилцан ярианд жүжгийн гол зөрчил илэрнэ. Монолог буюу өчил яриа нь үзэгчдэд хандахаас гадна хариу шаарддаггүй.</i></p> <p><i>Энэ чадварыг эзэмшүүлэхээс өмнө зохиолын өгүүлэгдэхүүний дарааллыг гаргана. Ингэхдээ дараах асуултыг хэрэглэж болно.</i></p> <ol style="list-style-type: none"> 1. Жүжигт хэдэн үзэгдэл байна вэ? 2. Үзэгдэл бүрийн агуулгыг ярина уу. 3. Зохиол хэрхэн эхэлсэн бэ? 4. Зохиол юунаас, ямар үйл явдлаас, эсвэл хэнээс олж өрнөв? 5. Өрнөл хэсэгт баатрууд хоорондоо яаж зөрчилдөж байна вэ? 6. Зохиолын туйл хэсэгт хэний сэтгэл санаа, үзэл бодол нь цуцаж туйлдаа хүрэв? Хэний сэтгэл санаа, үзэл бодол нь гайхамшигт ялалтаар дээд цэгтээ хүрэв? 7. Зохиол яаж төгсөв? Яагаад ингэж төгсгөв? <p><i>Жүжгийн зохиолын бүтэц, бүрэлдэхүүн хэсгийн холбоо хамаарлыг шинжлэн тайлбарлах чадварыг үнэлэхдээ дараах шалгуурыг баримтална.</i></p> <ul style="list-style-type: none"> • Жүжгийн найрал дууны хэсэг, ремарк, зохиолчийн тайлбар, харилцан яриа, өчил яриа зэргийг ялган таньж, оновчтой жишээ баримт татаж байвал • Баатруудын үйл хөдлөл, дохио зангаа, нүүрний хувирал, өөрчлөлт, дууны өнгө, хэлсэн үгийн сэтгэлзүйн утга, ярианы хурд, үйл явдлын байр байдал, завсарлага зэргийн үүргийг тодорхойлж, дүр бүтээсэнд үнэлгээ өгч байвал • Зохиолчийн тайлбарын үүргийг тайлбарлаж байвал • Жүжгийн найрал дууны хэсэг, ремарк, зохиолчийн тайлбар, үзэгдэл, харилцан яриа, өчил ярианууд нь ямар дарааллаар, яаж холбогдож байгааг жишээ баримт татан тайлбарлаж байвал 	<p>нарын бичсэн нийтлэл, шүүмж.</p> <ul style="list-style-type: none"> • Тухайлбал, Э.Оюун, Д.Намдаг, С.Хөвсгөл, П.Батхуяг, нарын шүүмж судалгааны өгүүлэл, Наранбаатар, Мөнхдорж, Болд, Батсайхан зэрэг нарын найруулагчдын үнэлгээ, дүгнэлтийг уншихыг санал болгож байна. • С.Хөвсгөлийн “Өрнө дахины уран зохиол” түүхэн найрууллууд ном, 2013 • А.Шархүү “Гадаадын уран зохиолын тойм” • Жишээлбэл, “urlag.mn” сайтаас татсан дараах мэдээлэл дээр багш хэрхэн чиглүүлж сурагчдын тайлбарлах чадварыг хөгжүүлж болох вэ гэдгээ уг удирдамжийн “сурах үйл ажиллагаа” хэсэгт байгаа асуултыг хэрэглэж болно.
<p>11.1г. Шүүмжийн санаа, шүүмжлэгчийн үнэлгээ,</p>	<p>Шүүмжийн санаа, шүүмжлэгчийн үнэлгээ, дүгнэлтийг тайлбарлахдаа:</p> <p>- Мэргэжлийн судлаач болон уншигч, үзэгчийн өгүүлсэн Гамлет зохиолын талаарх санал бодол, шүүмжийг эрж хайн, цуглуулах</p>	

дүгнэлтийг тайлбарлах	<ul style="list-style-type: none"> - Цуглуулсан материалыг уншин судлах, ингэхдээ жүжгийн ямар онцлог, аль талыг нь харж, шүүмж бичсэнийг ажиглах. Тухайлбал: Дүр, дүрийн сэтгэл зүй Зохиолын утга санаа Зохиолчийн бичлэгийн арга барил, үг хэлний сонголт, найруулга - Шүүмжийн санааг тодорхойлон ярих, ярихдаа өөрийн үзэл бодлыг тусгах <p>Дараах асуултыг хэрэглэж болно.</p> <ol style="list-style-type: none"> 1. Шүүмжлэгч зохиолыг хэр задлан шинжилсэн байна вэ? 2. Шүүмжлэгч шүүмжээрээ юуг хэлэхийг хүссэн бэ? 3. Шүүмжлэгч жишээ баримтыг ямар зорилгоор татсан байна вэ? 4. Шүүмжлэгч юуг онцолж үнэлсэн байна вэ? 5. Ямар дүгнэлт өгсөн байна вэ? Дүгнэлтийг уншаад юу бодогдсон бэ? 6. Шүүмжлэгчийн санаа, үнэлгээ, дүгнэлттэй санал нийцэж байна уу? Яагаад гэдгээ тайлбарла. Хэрэв нийцэхгүй байвал яагаад гэдгээ тайлбарлана уу. 	
-----------------------	--	--

1. XVII зуун: Францын сонгодог хошин жүжгээс уншиж судлах

Суралцахуйн зорилт	Үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p>11.1а. Францын сонгодог жүжгийн зохиолоос уншиж, хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэх, сэтгэгдэл, мэдрэмж, үзэл бодлоо илэрхийлэх</p>	<p>Энэ суралцахуйн удирдамжийн хүрээнд Францын сонгодог жүжгийн зохиолоос орчуулгаар унших замаар сонгодог театрын талаарх мэдлэг хийгээд тайз дэлгэцийн бүтээлийн хам сэдэвт дүн шинжилгээ хийх чадвар эзэмшинэ.</p> <p>Сонгон судалсан жүжгийн хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэх, сэтгэгдэл мэдрэмж, үзэл бодлоо илэрхийлэхдээ:</p> <p>А. Хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэхдээ:</p> <ul style="list-style-type: none"> – Жүжгийн агуулгыг ойлгож мэдэрч унших – Францын нийгмийн ямар цаг үе дүрслэгдсэнийг хам сэдвийн хүрээнд тайлбарлах – Жүжигт ямар асуудал дэвшүүлэн тавьсныг ярилцах – Дэвшүүлэн тавьсан асуудлыг нийгэм, соёлын болон түүхийн хам сэдвээр нь ялгах – Францын нийгэм, цаг үеийн онцлогийн талаар түүхийн хичээл болон өмнөх мэдлэгтэйгээ холбон тайлбарлах – Театрын хэлийг энгийн ярианы хэлээр сэлбэсэн гэж үнэлэгддэгийн учрыг баримтаар нотлох <p>Б. Үзэл бодлоо илэрхийлэхдээ:</p> <ul style="list-style-type: none"> – Зохиолчоос дүрийн эерэг ба сөрөг талыг уншигчдад ухааруулахад хэрхэн хандуулж байгааг зохиолоос жишээ татан тайлбарлах – Ёс суртахууны эрхэм чанарыг хэрхэн гаргасныг тайлбарлах – Үйл явдлын өрнөлтөд нөлөөлж байгаа хэрэг явдал саад бэрхшээлүүдийг гаргаж ирэх 	<p>Францын сонгодог жүжгээс</p> <p>Ж.Б.Мольер “Тартюф” <i>Өрнө дахины уран зохиолын дээж бичиг.</i> 1-р дэвтэр. Эмхтгэсэн С.Хөвсгөл нар. УБ., 2010</p> <p>Хөвсгөл С. <i>Өрнө дахины уран зохиол</i> (түүхэн найрууллууд). УБ., 2006</p> <p>Энхбаяр С. <i>Утга зохиолын онол.</i> Нэмэн засварласан 3 дахь хэвлэл. УБ., 2011</p>

- Дүр хоорондын зөрчилдөөн туйл руу хэрхэн хөтөлж байгааг баримтаар нотлох
- Хувь хүний болон нийгмийн үнэт зүйлийг хэрхэн гаргаж ирснийг тайлбарлах
- Үйл явдлын огцом эргэлт, санаанд оромгүй тайлал зэргээс амьдралын сайн мууд ул суурьтай, аливаад авах гээхийн ухаанаар хандах зэрэг зохиолын үнэт зүйлийг тайлан тайлбарлах
- Хошигнол бүтээж буй аргуудыг гаргаж, баримтаар нотлох
- Энэ жүжигт эмгэнэлийн элемент байгаа эсэхээр өөрийн үзэл бодлоо илэрхийлэх

<https://mn.wikipedia.org/wiki/http://mongolcom.mn/read/3231>

<https://mn.wikipedia.org/wiki/%D0%A2%D0%B0%D1%80%D1%82%D1%8E%D1%84>

В. Мэдрэмжээ илэрхийлэх

- Зохиолоос францын тухайн үеийн нийгмийн онцлогтой холбогдож илэрсэн мэдрэмжээ тайлбарлах
- Зохиолын дүрүүдтэй холбоотой илэрсэн мэдрэмжээ тайлбарлах
- Дүрийн өсөлт, бууралтыг тодорхойлж, түүгээр дамжиж илэрсэн мэдрэмжээ тайлбарлах
- Дүрүүдийн үг, үйлдлээс инээж, шоолж, жигшин зөвүүцэж, хөхүүлэн дэмжиж, өрөвдөж энэрч, бахархан дуурайх сэтгэлийн олон өнгө аясыг гарч байгааг нотлох, тайлбарлах

Багшид зөвлөх нь:

Уг жүжгийг уншиж судлах алхмыг нь багш урьдчилан хэлэх нь зүйтэй. Үйл явдлыг нь тодорхой гаргах асуултыг бэлтгэж өгөхөөс гадна, дүрүүдийг задлан шинжлэх, тухайн дүрийн зан төрхийн хувиралд нөлөөлж байгаа зүйл нь юу байгааг тодорхойлуулах, инээдэмт байдал нь юундаа байгааг тайлбарлуулах, хошигнолыг илрүүлж байгаа аргыг тодорхойлж, жишээгээр батлуулахад анхаарна.

Уг жүжгийг хүүхэд бүрээр уншуулж, театрт тавьсан жүжгийг нь үзүүлэхэд багш гойд анхаарах хэрэгтэй. Ингэснээрээ сурагчид эх зохиолоосоо театрт тавигдсан байдал нь юугаараа ялгарч байгааг олж харах юм.

<p>11.1в. Жүжгийн зохиолын бүтэц, бүрэлдэхүүн хэсгийн холбоо хамаарлыг шинжлэн тайлбарлах</p>	<p>А. Сэдэв, утга санаа, хам сэдвийн холбоо хамаарлыг тодорхойлохдоо:</p> <ul style="list-style-type: none"> - Жүжгийн сэдэв утгыг тодорхойлж, далд утгыг тайлбарлах - Классизмын гурван нэгдлийн дүрмийн тусгал болсон зохиол эсэхийг тайлбарлах, батлах /нэг байранд, 24 цагийн дотор, үйл явдлын нэг шугамын дагуу өрнөж төгсөж байгаа/ - Францын нийгэм, соёл иргэншлийн талаах ойлголт энэ жүжигт хэрхэн илэрснийг тайлбарлах - Нийгэм, шашин, соёл, түүхийн хам сэдэв хэрхэн илэрч байгааг тайлбарлах - Энэ жүжгийн тайзны бүтээл болгох үеийн багаж нь юу болохыг тайлбарлах - Нэгэн үйл эрчимд төвлөрсөн хэрэг явдал цуварч байгаа эсэхий үзэж тайлбарлах - Гол баатрын хүслийг боогдуулж, хэрэгжүүлэхэд саад болж байгаа үйлдэл, дүрийг тайлбарлах - Жүжгийн зохиолд, жүжгийг найруулсан тавихдаа андуурлыг хэрхэн гаргасан байдалд харьцуулалт хийх <p>Б. Далд утгыг тайлан тайлбарлахдаа:</p> <ul style="list-style-type: none"> - Тартюфын зайлшгүй доройтол, зан суртахууны уналт, урвалт шарвалтаар дамжуулж ямар асуудал дэвшүүлснийг тайлбарлах - Органы өөрчлөлтөөр дамжуулж ямар асуудал дэвшүүлснийг тайлбарлах 	
	<p>А. Зохиомжийн бүрэлдэхүүн хэсгүүдийг тодруулахдаа:</p> <ul style="list-style-type: none"> - Бүлэг бүрийн агуулгыг ярицлах - Үзэгдэл бүрийн агуулгыг ярилцах - Жүжгийн эхлэл хэсэгт дүрслэгдэх зүйлс нь юу байгааг ойлгох, тайлбарлах - Зангилааг үүсгэж буй зөрчлийг тодорхойлох, жүжгээс жишээ авч тайлбарлах - Өдөөн хатгалга, далд явуулга нь жүжгийн зангилаанд хэрхэн нөлөөлж буйг тайлбарлах - Үйл явдлын өрнөл нь ямар ямар үйлдлүүдээс бүтсэнийг гаргаж нотлох - Зөрчлийн өрнөл нь ямар дүрийн хүсэл зорилготой үл нийцэж, ямар дүрийн хүсэл зорилгыг дэмжиж байгааг ойлгож тайлбарлах - Өдөөн хатгалга, далд явуулгын туйлдаа хүрч буй хэсгийг олж тайлбарлах - Жүжгийн тайлал нь хэрхэн илэрч байгааг гаргаж энэ нь гадны хүчний оролцоотойгоор шийдэгдсэн үү, эсвэл дүрүүдийн хоорондын харилцаагаар шийдэгдсэн үү гэдгийг баримтаар нотолж тайлбарлах <p>Б.Зохиомжийн онцлог нь зохиолын утга санаанд хэрхэн нөлөөлж байгааг тайлбарлахдаа:</p> <ul style="list-style-type: none"> - Тартюфын өдөөн хатгалга, далд явуулга тодорхой шатанд ирээд зогсвол зохиолын үйл явдал хэрхэн өрнөх талаар ярилцах - Ямар дүрүүдийн харилцаа нь зохиолын утга санааг тодруулахад нөлөөлж байгааг тайлбарлаж , баримтаар нотлуулах <p>А. Дүрийн бодгаль ба нийтлэг шинжийг тодорхойлохдоо:</p>	

- Ж.Б.Мольерын жүжигт хүний зан төлвийн нэг шинжийг тод томруун харуулсан бол “Тартюф” жүжигт аль шинжийг гаргасан байгааг зохиолын үйл явдлаас гаргуулах
- Дүр хоорондын болон дүрүүдийн дотоод сэтгэлийн зөрчил давуу илэрч байгаа жишээг тайлбарлах
- Дүрүүдийн учирч байгаа саад бэрхшээл тэдний ямар зан чанарыг ил гаргаж байгааг тайлбарлах
- Дүрүүдийн зан авир, амьдралын зорилго, харилцаа, хандлага нь тогтвортой эсвэл өөрчлөгдөж байна уу гэдгийг дүрүүдийн үг үйлдлээс тодорхойлох
- Дүр хоорондын харилцан яриа ямар зорилго агуулж байгааг тайлбарлах
- Дүрүүдийн хэлсэн үг нь зан төрхийг тодорхойлоход ямар үүрэг гүйцэтгэж байгааг илрүүлэх
- Дүрүүдийн хийсэн үйлдэл нь тэдгээрийн зөн төрхийг тодорхойлоход ямар үүрэг гүйцэтгэж байгааг тайлбарлах
- Ямар учраас энэ дүр ийм үйлдэл хийв гэдгийг дүр тус бүр дээр гаргаж ирэх

Б. Дүрийн өсөлт нь зохиолын сэдэв, утга санаанд хэрхэн нөлөөлж буйг тайлбарлахдаа:

- Жүжгийн дүрийн өсөлт байна уу?
- Дүрийн өсөлт байна гэвэл энэ нь гурван нэгдлийн дүрэмтэй харшлах уу? гэж асуулт дэвшүүлэн ярилцах
- Дүрийн өсөлт байна гэж үзвэл энэ нь бусад дүрийн ямар зан чанарыг тодруулж байгаа жүжгээс жишээ авч нотлох

А. Зохиолын гадаад ба дотоод орчныг тайлбарлан дүгнэхдээ

- Ямар цаг үе, нийгмийн орчин, газар оронд зохиолын үйл явдлыг өрнүүлж энэ нь зохиолын сэдэв, утгад хэрхэн нөлөөлж байгааг тайлбарлах
- Ямар орчин дүрийн зан төрхийг илүү гаргаж байгааг тайлбарлах

Б. Зохиолын гадаад ба дотоод орчин нь дүрийг тодруулахад хэрхэн нөлөөлж байгааг ярилцахдаа

- Нийгэм цаг үеийн онцлог нь дүрийн зан төрхийг тодруулахад хэрхэн нөлөөлж байгааг илрүүлэх
- Дүрүүдийн харилцаа нь дүрийн зан төрхийг илрүүлж, тодруулахад хэрхэн нөлөөлж байгааг тайлбарлах

Зохиолын найруулгыг судлахдаа:

- Зохиолын орчуулга нь дүрийн зан төрхийг тодруулж чадсан эсэх дээр ярилцах, үзэл бодлоо хуваалцах

А. Утга шилжүүлэн дүрсэлсэн үг хэллэгийг таних, үндсэн утгаас шилжсэн ямар утга гарч байгааг ажиглах

- Дүрүүдийн хэлж буй үг, харилцан яриа нь дүрийн зан төрхийг тодруулахад хэрхэн нөлөөлж байгааг тайлбарлах
- Зусарч зулгуйч, дээрэнгүй, аялдан дагалдсан, бусдад өөрийн бодлоо тулган хүлээлгэж байгаа зэрэг зан чанар нь ямар үгээр илэрч байгааг тайлбарлах

Б. Зохиолын хэл яриаг илүү үр дүнтэй болгохын тулд хэрэглэсэн уран дүрслэл ба яруу хэрэглүүрийн хэрэглээг шинжлэх

- В. Бичил дүрслэлийн хэрэглээг тайлбарлах

Багшид зөвлөх нь:

Баагийн зүгээс энэ жүжгийг бүрэн эхээр нь уншуулахад анхаараарай. Үйл явдал хөөж, инээдэмт байдлыг нь онцлон уншихаас илүүтэйгээр ёс суртахууны болон гоо зүйн хувьд үнэ цэнэтэй зүйлийг нь эрж хайж, хариулт авахыг хүсэж байгаа тэр л санааг олоход туслаарай. Ингэж уншихдээ танил бус орчин, үг, хүний нэр зэргийн учрыг ухаарч, хэлсэн үг, хийсэн үйлдэл, бодсон бодлоос нь дүрүүдийн хувь заяаг нээн илрүүлж унших нь чухал. Надтай, бидэнтэй адил учраас эерэг дүр болж, эсвэл надтай болон биднээс тэс өөр учраас эсрэг дүр болж ойлгогдох зүйл гарч ирнэ. Энэ алдаатай хандлагаас болгоомжилж жүжгийн зохиолоос юу харж, сонсож, хүртэж байгааг тоочуулан бичиж тайлбарлуулах зүйтэй.

Жүжгээс түүх, соёл, нийгэм, шашны хам сэдвийг олуулж, яагаад ингэж үзэж байгаа талаар саналыг сонсоорой.

Бүлэг бүр дэх үйл явдлын өрнөж байгааг газрыг тоочин гаргаснаар жүжгийн үйл явдлын өрнөж байгаа ерөнхий газар орон зангидагдана. Үйл явдал нэг газар оронд өрнөнө / орны нэгдэл/ гэсэн гурван нэгдлийн дүрмийн нэгийг ийм байдлаар дүгнэж болно.

Бүлэг бүрийн агуулгыг нэгтгэн ярилцсанаар жүжгийн ерөнхий агуулга гарна. Үүнээс үйл явдлын нэгдэл нь гарч ирнэ. Орны болон үйл явдлын нэгдлээс цагийн нэгдлийг гаргуулаарай.

Үүний дараа өгүүлэгдэхүүний задлал хийлгэвэл жүжгийн агуулгыг бүхэлд нь гаргахад дөхөмтэй байх болно. Зангилааг үүсгэж буй өдөөн хатгалга, далд явуулга нь ямар дүрээс гарч байгааг ярилцах нь жүжгийн үйл явдлын өрнөлтөд чухал нөлөөтэй. Хатагтай Пернелийн Тартюфыг өмөөрч байгаа нь уу, эсвэл Органы гэр бүл өөрийгөө мартан, гэнэн хөнгөн аашилж, Тартюфыг хаацайлж байгаа нь уу, охиноо Тартюфтай суулгах гэж зүтгэж байгаа Органы шийдвэр үү гэх мэтээр ярилцаж сурагчдын саналыг сонсох нь зүйтэй.



Үүний дараа үйл явдлын өрнөлийг гаргах бөгөөд ямар ямар үйлдэл үүнийг бүрдүүлж байгааг гаргах нь зөв. Зөрчлийг туйлд нь хүргэсэн үйлдэл юу байсан, энэ нь хэрхэн тайлагдсаныг баримтаар нотлуулаарай. Гэхдээ гадны хүчний нөлөөгөөр үү, эсвэл дүр хоорондын харилцаагаар шийдэгдсэн үү гэдгийг баримтаар нотлон гаргуулах нь зөв юм. Үүний дараа жүжиг хэрхэн төгссөнийг ярилцаад санаанд оромгүй эргэлт гарч ирсэн бол тэр нь юу болох талаар дүгнэлт хийлгээрэй.

Тартюфын өдөөн хатгалга, далд явуулга нь аль нэгэн үйлдэл хийгээд зогсвол жүжгийн үйл явдал хэрхэн өрнөж, зохиолын утга санаанд ямар өөрчлөлт орох талаар таамаглал гаргуулаарай.

Дүрүүдийн зан араншин, амьдралын зорилго, харилцаа, хандлага нь тогтвортой байна уу? эсвэл өөрчлөгдөж байна уу гэдгийг дүрүүдийн үг үйлдлээс тодорхойлуулахад анхаараарай. Үүнийг Орган, Тартюф, Эльмира, Пернел, Мариана, Валер гэх мэт ер нь жүжгийн бүх дүр дээр гаргаж ирвэл дүгнэлт гаргахад нэлээд дөхөмтэй байх болно. Тухайлбал: Тартюфын хувьд зан араншин нь нөхцөл байдлаас шалтгаалж өөрчлөгдөж байна. Амьдралын зорилго нь тогтвортой байна. Бялдуучлал, бэртэгчин байдал нь түүний хөдөлмөгүй зорилго. Харилцаа, хандлага нь нөхцөл байдлаас шалтгаалаад өөрчлөгдөж байгаа учраас тогтворгүй хөдөлгөөнт дүр юм гэх мэтээр дүгнэж, үүнийг нь жишээгээр батлуулах хэрэгтэй.

	<p><i>Дүрийн өсөлт энэ жүжигт илэрч байна уу? Хэрвээ байна гэж үзвэл энэ нь гурван нэгдлийн онолтой нийцэх үү гэдгийг асуудал дэвшүүлж ярилцлага өрнүүлэхийг хичээгээрэй.</i></p> <p><i>Хошигнол бүтээх арга бол хошин зохиолын хамгийн чухал зүйл. Энэ жүжигт нөхцөл байдлын хошигнол, зан төрхийн хошигнол, учир зүйн хошигнол, дохио зангааны хошигнол, үг хэлний хошигнол зэргээс аль нь илүү түлхүү илэрч байгаа жишээгээр нотлуулж гаргуулаарай.</i></p> <p><i>Нөхцөл байдлын хошигнол нь зохиогчийн дүрслэн бодож олсон өдөл, сэдэл хатгаасын дундах нөхцөл байдлаас үүсдэг. Тухайлбал: Органыг ширээн доогуур оруулчхаад Эльмира Тартюфыг өдөж, үг алдуулж байна. Тартюф өөрийн энэ байдлыг Орган мэдсэнийг хараад гэмших биш харин ч бүр уурлаж хашгичиж байгаа нь нөхцөл байдлын хошигнолын жишээ. Зан төрхийн хошигнолын жишээ нь мөн л Тартюф дээр гардаг. Тэрбээр Далан худалч шиг алиа марзан үг, үйлдлээр биш, тэнэг мулгуу үйлдлээсээ болж өөрөө инээдэмт байдалд орж, бусдын инээдийг хүргэж байна. Дүрийн бодгаль шинжийн гол илрэл нь энэ нэр дэлхийн урлаг, утга зохиолын түүхэнд хоёр нүүртний ерөнхий нэр болсонд оршиж байгааг чухалчлан үзээрэй.</i></p> <p><i>Энэ зохиолыг уншаад, эсвэл театрт тавьсан жүжгийг үзээд, идэж, авахын үл ханах үйлдэл, зан суртахууны хувирал өөрчлөлт, уналт зэрэг нь жүжгийн хошин үйлдэл нь болж байна гэсэн дүгнэлт хийгээрэй.</i></p>	
--	---	--

2. XVIII зууны Германы уран зохиолоос уншиж судлах

Суралцахуйн зорилт	Үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p>11.1a Германы сонгодог зохиолоос уншиж, хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэх</p>	<p>А. Хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэхдээ:</p> <ul style="list-style-type: none"> - Гётед Фауст жүжгээ бичих санаа бүр 1770-аад онд төрсөн боловч эцсийн хувилбарыг нас барахаасаа ганцхан жилийн өмнө 1831 онд бичиж дуусгасан тул тухайн цаг үеийн нийгэмтэй холбон тайлбарлах - Тэрбээр энэ жүжгээ олон түмний дунд ихэд дэлгэрсэн доктор Фаустын тухай герман ардын домгоос сэдэвлэн бичсэн тул ардын домгийг харьцуулах - Байгаль, ертөнцийн зүй тогтолыг хэрхэн илэрхийлснийг тайлбарлах - Гүн ухааны агуулга хэрхэн илэрч байгааг тайлбарлах <p>Б. Үзэл бодлоо илэрхийлэхдээ:</p> <ul style="list-style-type: none"> - Тухайн зохиол дэлхийн уран зохиолд ямар үүрэг гүйцэтгэснийг судалж, дүгнэх - Энэ жүжиг нь хэдийгээр эмгэнэлт зохиол гэж тооцогддог ч хошин зохиолын элемент ч байгааг судлан тайлбарлах - Ёс суртахууны хэмжүүр, үүрэг хариуцлагаар үнэт зүйлийг хэрхэн ухааруулж байгааг жишээ, эшлэл татан тайлбарлах <p><i>Багшид зөвлөх нь:</i> <i>Мефистофель ард олныг дарлаж, хэлмэгдүүлж байдаг, дотроо эв нэгдэлгүй, дайн хямралтай хаант улсын тухай, алдар гавьяаны тухай яриад Фауст “Унан босон, босон унасаар, унаад босохгүй цаг ирэх вий” хэмээн улс орноо мөхөл, бутрал, тэмцэлд хүргэсэн ноёлогч ангид дургүйцнэ.</i></p>	<p>Гёте Й.В. Фауст: Эмгэнэлт жүжиг /Орч.С.Батбилэг.- УБ.:Мон Судар, 2009 Боть 24.- 326х.-ISBN 978-99929-0-805-X</p>   <p>Дараах хаягуудаар орж жүжгийн талаар унших www.urlag.mn/post/472.htm</p>

	<p><i>Мефистофель, Фаустыг өдөн ятгасаар дайтаж буй талын нэгэн этгээдийнх нь цэргийн ерөнхий командлагч болгосон боловч Фауст дайныг жигшин тэр ажлыг орхиж байна. Энд бас зохиолчийн дайныг эсэргүүцсэн үзэл санаа тусгалаа олж байгааг илрүүлвэл сайн.</i></p>	<p>https://mn.wikipedia.org/.../Иоханн Во льфганг фон...</p>
<p>11.1в Жүжгийн зохиолын бүтэц, бүрэлдэхүүн хэсгийн холбоо хамаарлыг шинжлэн тайлбарлах</p>	<p>А. Сэдэв, утга санаа, хам сэдвийн холбоо хамаарлыг тодорхойлохдоо:</p> <ul style="list-style-type: none"> - Гол баатар нь бiхнийг танин мэдэх эгээрэлдээ хетлегден, муу муухайн хичнiйдтэй сергелдеж, эцэст нь бурханлиг ариун бүхний iнэ цэнийг таньж үүрдийн авралд хүрч байгааг харуулсныг тайлбарлах <p>Б. Далд утгыг тайлан тайлбарлахдаа:</p> <ul style="list-style-type: none"> - Зохиолд үгээр бичигдсэн утга санаа болон үгээр илэрхийлэгдээгүй далд санааг гаргаж тайлбарлах. - Зохиолд байгаа танил биш үгийн утгыг тайлбарлах. <p>А. Зохиомжийн бүрэлдэхүүн хэсгүүдийг тодруулахдаа:</p> <ul style="list-style-type: none"> - Жүжиг нь “Театр дахь эхлэл”, “Тэнгэр дэх эхлэл” гэсэн хоёр удиртгал, хоёр үндсэн хэсэгтэй, I хэсэг нь 25 үзэгдэлтэй, II 5 бүлэг 26 үзэгдэлтэй байгааг ойлгож тайлбарлах <p>Б. Зохиомжийн онцлог нь зохиолын утга санаанд хэрхэн нөлөөлж байгааг тайлбарлахдаа:</p> <ul style="list-style-type: none"> - Хэсэг тус бүрт гарч байгаа харилцан яриа, дүрүүдийн тодорхойлол гэх мэт нь зохиолд ямар үүрэгтэй байгааг тайлбарлах <p>А. Дүрийн бодгаль ба нийтлэг шинжийг тодорхойлохдоо:</p> <ul style="list-style-type: none"> - Нийгмийн янз бүрийн давхраа, тэдний үзэл бодол, сонирхлыг төлөөлсөн олон хүн оролцож байгаагаас хэн хэнд байгаа шинжүүд нийтлэг болохыг тайлбарлах - Гол дүрүүдийг туслах дүртэй харьцуулж ямар ижил болон ялгаатай тал байгаа, эдэнд байгаа шинж нь хүмүүст түгээмэл, нийтлэг дүр мөн эсэх талаас нь судлах <p>Б. Дүрийн өсөлт нь зохиолын сэдэв, утга санаанд хэрхэн нөлөөлж буйг тайлбарлахдаа:</p> <ul style="list-style-type: none"> - Фаустын дүрийн өсөлт, бууралт бусад дүрүүдийн өсөлт, бууралтаас юугаар ялгаатай байсныг учир шалтгаан талаас нь тайлбарлах <p>А. Зохиолын гадаад ба дотоод орчныг тайлбарлан дүгнэхдээ</p> <ul style="list-style-type: none"> - Дүр амилах нөхцөл байдлын тохироо, цаг хугацааг судлах - Зохиолын орчинг бүрдүүлсэн үг хэллэг, өнгө аяст үнэлгээ хийх - Зохиолчийн бүтээсэн орчин, нөхцөл дүрийнхээ сэтгэлзүйн байдлыг тодруулахад хэр оновчтой байсанд үнэлгээ өгөх <p>Б. Зохиолын дотоод орчин (дүрүүдийн хоорондох харилцааны уур амьсгал) нь дүрийг тодруулахдаа хэрхэн нөлөөлж буйг тодорхойлохдоо:</p> <ul style="list-style-type: none"> - Дүрүүдийн харилцан яриаг судалж, хоорондын харилцаа нь таатай болон таагүй уур амьсгалыг бүрдүүлж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх - Дүрүүдийн харилцаанаас дүрийн зан төрх, сэтгэл зүйн онцлогийг тодорхойлох - Зохиолч ямар үг, ямар уран дүрслэлийг сонгож дотоод орчныг бүрдүүлж, дүрээ бүтээснийг үнэлэх - Зохиолын найруулгыг судлахдаа: 	<p>А.Шархүү нарын бичсэн “Гадаадын уран зохиол” II дэвтэр УБ.,1984 он номыг ашиглаж болох</p>

- Тухайн зохиолчийн бичих арга барилд өвөрмөц байдлаар бүрэлдэж төлөвшсөн, дахин давтагдашгүй онцлог шинжүүдийн төгс цогцлолыг уран сайхны найруулга талаас нь задлан шинжлэх.
- Фауст жүжиг маш урт бөгөөд “уншихад зориулсан драм” хэмээн тодорхойлогддогийн учрыг тайлбарлах
- Д.Батбаяр судлаач “Цаг хугацааны нэсээр бичигдсэн бүтээл” гэж үнэлсэн байдгийг учрыг зохиолчийн найруулах эрдэмтэй холбон тайлбарлах гэх мэт.

А. Утга шилжүүлэн дүрсэлсэн үг хэллэгийг таних, үндсэн утгаас шилжсэн ямар утга гарч байгааг ажиглах

Б. Зохиолын хэл яриаг илүү үр дүнтэй болгохын тулд хэрэглэсэн уран дүрслэл ба яруу хэрэглүүрийн хэрэглээг шинжлэх

В. Бичил дүрслэлийн хэрэглээг тайлбарлах

“Шулмын гал тогоо” хэмээх агуйд аваачин, Фаустыг залуу болгож байна. Энд хүн байгалийн нууцыг тайлж чадахгүй гэж буй шулмын үг, мөн түүний уншиж буй утга холбоогүй тарни зэргээр зөрчилтэй үзлийг илэрхийлснийг тайлбарлах гэх мэт.

Багшид зөвлөх нь

Фауст зовж зүдрэн будилж төөрөн эрэлхийлсээр эцсийн эцэст үнэнийг олсон гаргалгааг сурагчид олж тайлбарлах.

Түүний амьдрал алгуурхан бөхөж, Фауст гуйвлан унана.

Энэ агшинг удтал хүлээсэн Мефистофель эрх ёсоороо түүний сүнсийг авахаар завдана. Гэтэл эцсийн мөчид чагаа тэнгэрүүд Фаустын сүнсийг чөтгөрийн яг хамар дороос нь шүүрэн авч оддог. Мефистофель анх удаа биеэ барьж чадалгүй цухалдаи тэчъядаж, өөрийгөө хараан зүхнэ. Фаустын сүнс аврагджээ. Энэ бол түүний амьдрал эцсийн дүндээ зөвтгөгдсөн гэсэн үг. гэх мэтээр зохиолын утга санааг сайтар ойлгож тайлбарлах нь чухал.

Жүжиг нь “Театр дахь эхлэл”, “Тэнгэр дэх эхлэл” гэсэн хоёр удиртгал, хоёр үндсэн хэсэгтэй. “Театр дахь эхлэл”-д театрын дарга, яруу найрагч, хошин жүжигчин гурвын яриа маргаанаар урлагын зорилго мөн чанарыг өөрийнхөө үзэл бодлоор тайлбарласан байна. Урлаг нь хүний нүд хуурах өнгө хэлбэрийн гоё сайхан биш, зохиолчийн удаан жилийн бодол санааг нэгтгэн илэрхийлсэн төгс үнэн сайхан байх ёстойн дээр орчин үеийнхээ эрэлт шаардлагыг хангахаас гадна хойч үед зориулагдсан байх ёстой гэсэн зохиолчийн үзэл бодлыг тусгасан.

“Тэнгэр дэх эхлэл”-д материалаг ертөнц мөнх, юм бүхэн үргэлжийн хөгжил хөдөлгөөнд оршихын зэрэгцээ ертөнц гайхамшгийн зохицол байдаг тухай гарна. Ийнхүү өөрчлөгдөн хувирч, мөнх орших байгалийн дэлгэц дээр оюун ухааныхаа улмаас хүн аз жаргалгүй зовж, зүдэрч байна. Учир нь нийгмийн ёс журам, хууль зүй зохисгүйг хүн ойлгож байгаа учир зовж байна. Нийгмийн энэ муу гайн гэм буруутан нь байгаль, ертөнц бус хүн өөрөө гэж Мефистофель батална. Үүнээс сурагчид удиртгал хэсэгт зохиолчийн урлагийг үзэх үзэл, байгаль ба хүний тухай, байгаль хүн хоёрын харилцан шүтэлцээний тухай үзэл илэрч байгааг ойлгон тайлбарлах чухал юм.

Фаустын дүрийн өсөлт, бууралт бусад дүрүүдийн өсөлт, бууралтаас юугаар ялгаатай байсныг учир шалтгаан талаас нь тайлбарлах

Фаустад ч эсрэг тэсрэг тал бий. Ялангуяа зохиолын хоёр баатар эл эсрэг тэсрэгийн төлөөлөл. Фауст үргэлж сэтгэл дундуур байхад Мефистофель илүү санах юмгүй дүүрэн сав

	<p>шиг ажээ. Нэг нь юмны цаана гарч, ихийг үзэх мэдэхийг хүснэ. Нөгөө нь цаашлаад цаашлаад юу ч олохгүй гэж үзнэ. Нэг нь хүний хүсэл үзүүргүй гэх бөгөөд нөгөө нь хормын төдий жаргалаар хүн хүсэл эрмэлзлээ алдана гэж байгааг хооронд нь холбон тайлбарлаж, нэгийн шалтгаанаас нөгөөгийн учир холбоог сурагчид тайлбарлаж байх нь чухал.</p>	
--	--	--

3. XIX зуун: Орчин үеийн драмын жүжгээс уншиж судлах

Суралцахуйн зорилт	Үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p>11.1a Драмын жүжгийн зохиолоос уншиж, хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэх</p>	<p>Үйл ажиллагаа 1 . Хам сэдэв хийгээд зохиогчийн холбоо хамаарлыг судлах Алхам 1. Сонгон унших Драмын жүжгийн үүсэл хөгжлийг төлөөлөх чанартай зохиолчдын бүтээлийг сонгон авч уншина. Алхам 3. Хам нөхцлийг судлах Тус зохиолчийн амьдарч асан цаг үеийн зонхилох үзэл санаа нь юу байсан бэ? Драмын жүжиг хөгжсөн үеийн нийгэм соёлын хам нөхцөл ямар байна вэ? Ибсений хам орчин нь Софоклын, Шекспирийн, Мольерын цаг орноос ялгарч байна уу? , Алхам 2. Хэлэлцүүлгийг ялган таних Дэлхийн шилдэг зохиолуудад үзэл сурталжсан, асуудал дэвшүүлэн хэлэлцсэн зөрчлүүдийг хэрхэн тусгасныг ялган танихад анхаарна. Тухайнд жүжигт ямар нэгэн нийгмийн ноёлох үзэл суртал юм уу асуудлыг хэлэлцэж байна уу? Тэр асуудал нь өнөөгийн бидний цаг үед ямар нэгэн байдлаар шийдвэрлэгдсэн байна уу? Аль эсвэл? 2. Хам сэдэв хийгээд уншигчийн холбоо хамаарлыг судлах Алхам 1. Сэтгэгдэл, мэдрэмжээ илэрхийлэх Ибсен баатруудын оронд, ялангуяа Норагийн оронд та байсан бол ямар шийдвэр гаргах байсан бэ? Тэдний байгаа нөхцөл байдлыг төсөөлж, мэдэрч байна уу? Та үүнтэй төсөөтэй нөхцөл байдалд орж байсан уу? Алхам 2. Үзэл бодлоо илэрхийлэх Бичвэрийн дотор хэлбэржсэн хэлэлцүүлэг болон үзэл суртлын хүрээнд өөрсдийн ялгаатай үзлийг л илэрхийлэх замаар “өөрийн эргэцүүлэлтэй” уншлагад суралцана. XIX зууны сүүл үеэс нийгмийн анхаарлын төвд гарч ирсэн ч өнөөг хүртэл хэлэлцэгдсээр байгаа ямар асуудлыг та олж харж байна вэ? Энэ тухайд та ямар үзэл бодол, байр суурьтай байна вэ? Туршлагаа хуваалцах асуултууд</p>	<p>Эх зохиолын орчуулга 1. Ибсен Г. <i>Нора</i>. Орчуулсан Э.Оюун, УБ., 1985</p> <p>Гарын авлага 1. 2. Галбаатар Д. <i>XX зууны өрнө дорнын уран зохиол</i>. Тэргүүн дэвтэр Модернизм, Постмодернизм, Нэн шинэ үе. УБ., 2013 3. Нандинбилиг Г. <i>Жүжгийн зохиолыг задлан шинжилж, заан сургахуй</i>. УБ., 2013 4. <i>Театр-75</i>. УДЭТ-ын 75 жилийн ойд зориулав. УБ., 2006</p>

	<ul style="list-style-type: none"> ○ “Хүүхэлдэйн байшин” зохиолыг уншсан хийгээд жүжгийг үзсэн туршлагаа хуваалцана уу. Хелмер хийгээд түүний өвчнийг эмчлүүлээд буруушаагдсан түүний эхнэр Нора хоёрын холбоог та хэрхэн тусгаж байна вэ? Норагийн зан суртахууныг та хэрхэн тусган авч байна вэ? Яагаад? ○ Хелмерийн дүрийг тодорхойл. Жүжиг эхлэхэд түүний дүрийг та ямар байдлаар хүлээн авсан бэ? Жүжгийн төгсгөлд таны бодол хэрхэн өөрчлөгдсөн бэ? Таны бодлыг өрчилсөн ямар баримтууд байна вэ? ○ Жүжгийн төгсгөлд Нора өөрийн гэрлэлтээ хэрхэн тодорхойлсон бэ? Энэ талаар таны үзэл бодол ямар байна вэ? <p>Алхам 3. Сэдэв, утга санаа, хам сэдвийн холбоо хамаарлыг тодорхойлох:</p> <p>Жүжгийн бичвэрийн бүтэц, онцлог чанарт задлан шинжлэл хийнэ.</p> <p>Реалист жүжиг нь домог зүй болон түүхээс сэдэвлэсэн байна уу? Эсвэл амьдралаас сэдэвлэсэн байна уу? Жүжигт үгээр хэлсэн ямар ямар санаанууд байна вэ? Тэдгээрээс гол утга санаа нь юу вэ? Тухайн нийгмийн хууль эрхийн харилцаа, эмэгтэйчүүдийн талаарх үзэл сэтгэлгээ ямар байна вэ?</p> <p>Алхам 4. Далд утгыг тайлан тайлбарлахдаа:</p> <p>Энэ бол зохиогчийн амьдарч асан цаг үеийн зонхилох үзэл санаа зохиолд хэрхэн туссан бэ? Зохиолч жүжгийн бичвэртээ ямар нэгэн далд санааг илэрхийлсэн үү? Үйлдвэржсэн, хотожсон нийгмийн хүн туйлын эрх чөлөөг хаанаас хайх ёстой вэ? Гэр бүл оршин тогтнохын үндэс нь юу гэж тэр үзүүлсэн бэ? Тухайн үеийн нийгэмд шинээр авч үзэх шаардлагатай ямар санаа түүний жүжгүүдэд гол шугам болж байна вэ? Тэрээр тус жүжигтээ эмэгтэйчүүдийг хэрхэн үзүүлсэн бэ?</p> <p><i>Багшид зөвлөх нь</i></p> <p><i>Хам сэдэвт судалгааны энэ хэлбэр нь бичвэрийн доторх зонхилох ба зөвшилцөх байр суурь, тэдний соёлын хэлэлцүүлэг болон үзэл суртлын талаарх уншигчдын төсөөллийг судалдаг. Бичвэрийн дотор хэлбэржсэн соёл түүхийн хам сэдэв хийгээд үзэл суртлын хүрээнд өөрсдийн ялгаатай үзлийг л илэрхийлж, цаашилбал “өөрийн эргэцүүлэлтэй” уншлагад суралцана. Үүнд:</i></p> <ul style="list-style-type: none"> • <i>Ёс суртхууны суурь үнэт зүйлсийг хамгаалах</i> • <i>Арьсны өнгө, гадаад үзэмжээр ялгаварлан үзэх байдлыг дэмжихгүй байх</i> • <i>Соёлын олон янз байдалд хүндэтгэлтэй хандах</i> • <i>Үгийн урлаг дахь эмэгтэйчүүдийн дуу хоолой болон нийгэмд эзлэх байр суурийг анхааран судлах гэх мэт</i> • <i>Өнөөгийн хам сэдэвт судалгааны бий болгоод байгаа идэвхтэй уншлагын үйл ажиллагаа нь бичвэрийн дотор хэлбэржсэн соёл түүхийн хам сэдвийн хэлэлцүүлэг (discourse) болон үзэл суртлыг (ideology) тодорхойлоход төвлөрдөг. Дэлхийн хам сэдэвт дэлхийн дайн, хүний наймаа, хар тамхи, арьстан угсаатны гадуурхлын асуудал болон хүйсээр ялгаварлах үзэл, их гүрний нөлөөлөл хараатын асуудал, хэл соёлын түрэмгийлэл болоод хүний эрх, эрх чөлөө, соёлын олон янз байдлыг хамгаалах зэрэг хэлэлцүүлгүүд хамаарна.</i> 	<p>/anirgum.blogspot.com/2015/02/blog-post_47.html http://www.shmoop.com/dolls-house/literary-devices.html</p> <p>ТУС ЖҮЖГИЙН 1984 онд манай театрын тайзнаа Э.Оюуны орчуулгаар тавигдсан ба жүжгийг Г.Доржсамбуу найруулсан ба 2014 онд УДЭТ-ийн тайзнаа дахин тоглосон байна .</p> <p>НЭМЖ СУДЛАХ ХАМ ОРЧИН</p> <ul style="list-style-type: none"> ✓ 2001 онд ЮНЕСКО тус жүжгийн гар бичмэлийг дэлхийн өвд бүртгэсэн ✓ Генрих Ибсений нэрэмжит Ибсен сангийн үйл ажиллагаа ✓ Европын орнуудад явагддаг Ибсен фестивал
	<p>Үйл ажиллагаа 3. Хам сэдэв ба бичвэрийн холбоо хамаарлыг судлах</p>	

11.1в
Жүжгийн
зохиолын
бүрэлдэхүүн
хэсгүүдийг
таньж, утга
санаанд
хэрхэн
нөлөөлж
байгааг
тайлбарлах

Реалист драм нь Софоклын, Шекспирийн, Мольерын жүжгүүдээс реалист жүжгүүдээс ямар онцлог шинжүүдээр ялгарч байна вэ? Тус жүжгийн зөрчил, үзэгдэл, дүр, бэлгэдэл, егөөдөл, тайз засал, орчин, уур амьсгал, өнгө аяс зэрэг нь ямархуу онцлогтой байна вэ?

- Кругстад, Доктор Ранк, К.Линдэ нарын дүрүүдийн үүргийг эргэцүүлэн тунгаа.
- Жүжгийн өгүүлэгдэхүүнийг тодруул. Ибсен өөрийн хариу үйлдлээ хэрхэн хянаж байна вэ? Жүжгийн үйл явдлын алхам хэмнэл хаанаас үүдтэй байна вэ?
- Зохиолоос харааны мэдрэхүйд хандсан ямар бичил дүрслэлүүд байна вэ? Тэдгээрээс эд юмсын бэлгэдлийн үүргийг таньж, тэдгээрийн утга учрыг тайлбарла.
- Жүжгийн нэг гол үзэгдлийг сонгож, дүрүүдийг илэрхийл. Хэрхэн жүжиглэж болохыг тайлбарла.

Алхам 1. Жүжгийн үзэгдлийг задлан шинжлэх

Энэ үеийн жүжигт эмгэнэлт жүжгийнх шиг онцгой содон зөрчлийг үзүүлсэн байна уу? Аль эсвэл тэр цаг үеийн нийгмийн аж амьдралд түгээмэл оршдог, нийт хүний хувь заяатай холбоотой нийтлэг зөрчлийг, үзүүлсэн байна уу? Өгүүлэгдэхүүний хувьд өндөр түвшинд боловсруулсан үзэгдлийн шалтгаант холбооны цуврал байна уу? Эргэлтийг бүтээх онцлог нь ямар байна вэ? Жүжгийн тайлал нь хэрхэн төгссөн бэ? Жаргалтай, зовлонтой ямар төгсгөл байна вэ?

Гэр бүлийн дотоод амьдралыг үзэгчдэд тусган үзүүлэхийн тулд шинээр загварчилж өгсөн зүйлс байна уу? Жүжигт Норагийн сэтгэл догдлол хийгээд сэтгэлийн дарамтыг хэрхэн үзүүлсэн бэ?

Алхам 2. Дүрийн бодгаль ба нийтлэг шинжийг тодорхойлж, зохиолын утга санаанд хэрхэн нөлөөлж байгааг тайлах

Театрын уламжлал бүр өөрийн ялгаатай хэв ёсыг тогтоосон байдаг. Орчин үеийн драмын жүжигт театрын уламжлалыг өөрчилсөн зүйлс нь юу байна вэ?

Жүжигт тэнгэр бурхдыг дүрсэлсэн үү? Эсвэл эгэл жирийн хүнийг дүрслэх байна уу? *Ибсений жүжигт гарч байгаа дүрүүд нь нийгмийг төлөөлж байна уу?* Жүжигт гарч буй баатруудын зөрчил хувь хүний зан суртхуунаасаа үүдэж байна уу? Аль эсвэл нийгмийн хүчин зүйлсээр тайлбарлагдах уу?



Алхам 3 Зохиолын гадаад ба дотоод орчин нь дүрийг тодруулахад хэрхэн нөлөөлж байгааг ярилцахдаа

Реалист драмд гэр бүлийн өдөр тутмын амьдралыг бүтээхдээ мөнгө санхүүгийн асуудлыг үзүүлдэг. Жүжигт мөнгө хөрөнгийг тухайн орон цагийн хамаарал дунд хэрхэн үзүүлсэн байна вэ? Реалист драмд орчныг бүрдүүлэхдээ жүжгийн тайз заслыг театрын аль уламжлалд үндэслэсэн байна вэ? Орчныг жинхэнэ харагдуулахын тулд юуг шинээр загварчилсан бэ? Тайз заслын нүдэнд харагдах деталь илэрхийллүүд нь жүжгийн санааг хэрхэн тодруулж байна вэ? Жүжигчдийн тайзан дээр байрлах байрлал, тэдгээрийн үгийн бус харилцаа дохио зангаа, үйл хөдлөл, тайзны ар тал, багана, тавиур хэрэгсэл, хувцас, гэрэлтүүлэг, дууны эффект ямар байхаар үзүүлсэн байна вэ? Хувцас хэрэглэл бол дүрийг тодорхойлж өгдөг гол зүйл байдаг. Г.Ибсений “Хүүхэлдэйн байшин” жүжигт Нора хэдэн удаа хувцсаа сольдог вэ? Эдгээр хувцасны өөрчлөлт бүр нь юуг илэрхийлж байна вэ?

Драмын жүжигт дүрүүдийн харилцааны уур амьсгалыг мэдрүүлэхийн тулд бэлгэдэл, егөөдлийг өргөн ашигладаг.

	<p>Жишээ нь: “Хүүхэлдэйн байшин” жүжгийн орчныг нарийвчлан авч үзвэл тэдний гэрлэлтийн мөн чанар болоод гэр бүлийн уур амьсгал дахь Хелмерийн нөлөөллийг бэлгэдсэн зүйлс юу байна вэ? Тайз заслын нүдэнд харагдах деталь илэрхийллүүд нь жүжгийн санааг хэрхэн тодруулж байна вэ? Тодруулбал ямар бэлгэдэлт эд зүйлсийг үзүүлсэн байна вэ? Энэ нь ямар далд утгыг илэрхийлэх вэ?</p> <p>Үнэлж дүгнэх асуултууд</p> <ol style="list-style-type: none"> 1. Норагийн зан суртхууныг дүгнэ. Түүний гэр бүлээ орхих шийдвэрийг зөвтгөж байна уу? Яагаад? 2. Ибсен зохиолоо “Хүүхэлдэйн байшин” гэж нэрлэсэн нь эмэгтэйчүүдийг зөвтгөх үзэлтэй хэрхэн холбогдож байна вэ? Тэр хэрхэн зөвтгөсөн гэж та бодож бана в? 3. “Хүүхэлдэйн байшин” зохиол нь Нора, Торвальд хоёрыг эвлэрүүлэн, Нора гэр бүлдээ үлдэж буйгаар төгсгөх алтернатив төгсгөлтэй бол ямар вэ? Энэ нь урлагийн болоод театрын үр нөлөөтэй төгсгөл мөн үү? Яагаад? <p>Багшид зөвлөх нь</p> <p><i>Энд драмын жүжгийн бичвэрийн зөрчил, үзэгдэл, дүр, бэлгэдэл, егөөдөл, тайз засал, орчин, уур амьсгал, өнгө аяс зэрэг бүрэлдэхүүн хэсгүүдийн өвөрмөц онцлогийг задлан шинжилнэ. Үүнд:</i></p> <ul style="list-style-type: none"> - <i>Жүжгийн үзэгдэл</i> - <i>Жүжгийн дүр</i> - <i>Жүжгийн харилцаа яриа</i> - <i>Театрын тайз засал: Орон, цаг</i> <p><i>Бичвэрийн хэл бол бодит байдлын тусгалыг бүтээхэд шийдвэрлэх ач холбогдолтой бөгөөд уншигчийн онцлог байр суурийг бүтээж, бас тэднийг ятгах гэх мэт тодорхой зорилгоор уншигчдад хаягласан хэлбэрүүд юм. Реалист драмд Шекспирын жүжгийн харилцаа ярианд үндэслэсэн хэдий ч зарим зүйлийг шинээр загварчилсан юм. Бичвэрийн хэл нь дан ганц түүхийг өгүүлдэггүй, ертөнцийн хувилбаруудын онцлогийг сурталчлах чимээгүй байдлыг ч багтаадаг. Энэ судалгааны үед бичвэрт юу гэж хэлж, бас юу гэж хэлэхгүй байгааг шинжлэн судлахад анхаарна.</i></p>	
<p>11.1г Шүүмжийн санаа, шүүмжлэгчийн үнэлгээ, дүгнэлтийг тайлбарлах</p>	<p>Алхам 1. Шүүмжийн санаа, шүүмжлэгчийн үзэл бодлыг задлан шинжлэх Энэ судалгааны үед тус зохиолын хам сэдэв, бичвэр, зохиолчийн талаарх шүүмжийг уншиж, баримт ба саналыг ялган танина</p> <p>Алхам 2. Утга зохиолын үйл ажиллагаанд оролцох Жүжгийн нээлт, уншигчдын бага хурал, уран бүтээлийн уулзалт гэх утга зохиолын орчинд өрнөж байгаа аливаа үйл ажиллагааг ажиглан оролцоно.</p> <p>Туслах асуултууд Энэ үйл ажиллагаа нь зохиолч төвтэй байна уу? Бичвэр төвтэй байна уу? Энэ үйл ажиллагаа нь ямар соёл, үзэл, хандлагыг дэмжиж байна вэ? Сурталчилгааны зорилготой байна уу? Аль эсвэл? Реалист драмын харилцаа яриа нь театрын аль уламжлалаас юуг суралцсан байна вэ? Юуг шинээр загварчилж оруулсан байна вэ?</p>	

XIX зууны францын романаас уншиж судлах

Суралцахуйн зорилт	Үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p>11.1a Өрнөдийн сонгодог тууж, романаас монгол орчуулгаар уншиж, хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэх, үзэл бодлоо илэрхийлэх</p>	<p>А. Хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэхдээ:</p> <ul style="list-style-type: none"> - О.Бальзакийн “Эцэг Горио” романыг бичсэн үе /1849/ буюу 19-р зууны 50-иад он нь өрнө дахины хөрөнгөтний нийгэм “зэрлэг капитализм” гэж нэрлэгдэн түүхэнд орсон хөгжлийнхөө хамгийн хүнд бэрх эхэн үе шатандаа байсан тэр цаг үеийн тусгал болон гарч ирсэн зохиол учир энэ түүхэн цаг үеийн талаар түүхийн хичээлийн мэдлэг, чадвартай холбон тайлбарлах - 19-р зууны 2-р хагасын 40-50-иад оны баруун Европын анхны хөрөнгөтөн орнуудын түүхэн хувь заяа, тэдгээрийн нийгэм, улс төр, эдийн засгийн харилцааны өвөрмөц түүхэн дүр төрхийг зөв ойлгож ухаарч, тайлбарлах - О.Д.Бальзакийн хөрөнгөтний нийгэмд дэх мөнгөний эвдлэн сүйтгэх ноёрхлын тухай “Хүн төрөлхтний шог” суут бүтээлд орсон “Эцэг Горио” романыг тухайн үеийн нийгмийн хам сэдэв талаас нь нэлээд өргөн хүрээнд холбон тайлбарлах - О.Д.Бальзакийг энэхүү “Шүүмжлэлт реализм”-ын урсгалын эцэг гэж нэрлэдэг. Энэ чиглэл урсгалын үзэл санаа зохиолд хэрхэн туссан талаас нь тайлан тайлбарлах <p>Б. Үзэл бодлоо илэрхийлэхдээ:</p> <ul style="list-style-type: none"> – Одоогоос 200 гаруй жилийн өмнөх Францад өрнөж буй аж үйлдвэржилт болон зах зээлийн чөлөөт өрсөлдөөн, анхны капитал хуримтлалын үе буюу анхны хөрөнгөтнүүд төрөн гарч байсан тэр цаг үе нь өнөөгийн зах зээлийн нийгэмтэй ямар талаараа адил төстэй, ялгаатай байгаа талаар харьцуулж, өөр өөрсдийн үзэл бодлыг илэрхийлэх – Анхны хөрөнгөтнүүдийн баяжиж хөлжихийн тулд яахаас ч буцахгүй байсан үе, хөрөнгө мөнгө хүний ёс зүй, ёс суртахууны эрхэм нандин бүхнийг хэрхэн үгүйсгэж, эцэг эх төрөл садны холбоо хүртэл өнгө мөнгөнд шунах шуналд зайгаа тавьж өгч байгааг “Эцэг Горио” зохиолд дүрсэлсэн талаар хэлэлцүүлэг хийх – Ёс суртахууны уналт ямар хүнлэг бус үйлдэл хийхэд хүргэдэг талаар “Эцэг Горио” зохиолын дүр, үйл явдал, утга агуулгаас жишээ баримт татан ярьж нотолж санал бодлоо солилцож мэтгэлцэх <p><i>Багшид зөвлөх нь</i> Энэ үеийн Францын уран зохиолыг “шүүмжлэлт реализм” гэж томъёолдог бөгөөд чухам тэрхүү түүхэн цаг үеийн нийгэм эдийн засгийн учир шалтгааныг зөв ойлгож ухамсарлах нь “Эцэг Горио” зохиолын утга агуулгыг ойлгоход сурагчдад илүү дөхөм байхад анхаарч хичээл болон бие даалтаа төлөвлөх нь зүйтэй. Мөн тухайн цаг үеийн буюу 19-р зууны 2-р хагасын 40-50-иад оны баруун Европын анхны хөрөнгөтөн орнуудын түүхэн хувь заяа, тэдгээрийн нийгэм, улс төр, эдийн засгийн харилцааны өвөрмөц түүхэн дүр төрхийг зөв ойлгож ухаарах нь чухлыг бас мартаж болохгүй.</p>	<p>О.Бальзак “Эцэг Горио” /Орч. Д.Батсүх, Т.Пүрэвжал.- УБ., Мон Судар, 2009 Боть 25.-288х</p>   <p>Эцэг Горио – УСК-г дараах линкээр орж ашиглаж болох</p> <p>http://teacher.sur.mn/read.aspx?content=f8b254fd-e0f0-42ba-8d79-9bf5a021f784</p>

	<p><i>Капитализмын эхэн үеийн энэхүү хүнд хэцүү цаг үед анхны капитал /хөрөнгө/ хуримтлагчдын зэрлэг догшин зан авир, хязгааргүй шунал хүсэл, ёс суртахууны доройтол, бүхнийг “зоосны нүхээр харах” болсноос үүдэлтэй ёс зүй, зан суртахууны уналт доройтол тэргүүтэн, түүхэн цаг үеийн нийгэм эдийн засгийн учир шалтгааныг зөв ойлгож ухамсарлах нь “Эцэг Горио” зохиолын утга агуулгыг зөв ойлгож ухаарахад зайлшгүй шаардлагатай хам сэдэв болно.</i></p>	
<p>11.16 Хүүрнэлийн учир холбогдлыг тодорхойлж, дуу хоолойг тайлбарлах</p>	<p>А. Хүүрнэлийн учир холбогдлыг тодорхойлохдоо:</p> <ul style="list-style-type: none"> - “Эцэг Горио” романд зохиомжийн үндсэн нэгжүүдээс хамгийн их өргөн дэлгэр хэрэглэсэн нь хүүрнэлийн арга маяг юм. Ерөөс реалист хэв маягийн уран зохиолын бичлэг туурвилзүйн үндсэн хэв маяг нь хүүрнэлийн арга болдог бөгөөд чухам энэ учир шалтгааныг суралцагчид энэ зохиолыг уншиж тайлбарлахдаа өөрсдийн итгэл үнэмшил, нотолгоо болгон иш татаж тайлбарлах - Хүүрнэлийн арга нь зөвхөн эд хөрөнгө, ашиг орлогын хойноос улайран хөөцөлдөж ёс зүй ёс суртахуун хэмээх эрхэм үнэт зүйлийг огтхон ч хайхралгүй хаясан нь эцэстээ ямар эмгэнэлт төгсгөлд хүргэж байгаа гашуун түүхийг хүүрнэн өгүүлэх арга маягийг сонгон авч бүтээсэн зохиолын эмгэнэлт болон шүүмжлэлт утга санааг гаргахад хэрхэн зохицсоныг өөрсдийн итгэл үнэмшлээр тайлбарлан тодорхойлох <p>Б. Дуу хоолойг тайлбарлахдаа:</p> <ul style="list-style-type: none"> - О.Д.Бальзак хэдийгээр “Эцэг Горио” зохиолдоо шууд илээр хөрөнгөтөн нийгэм буруу хөгжиж байна, хөрөнгөтнүүд хэтэрхүү шунаж, ёс зүй ёс суртахууны доройтолд орсон байна гэх мэтээр ил цагаан шүүмжлээгүй боловч өөрийн зохиол бүтээлүүдээр тухайлбал “Эцэг Горио” зохиолынхоо үйл явдал, дүр, баатруудынхаа бодол сэтгэл, амьдралын хэвшил, ааш зан, ёс зүй ёс суртахууны төлөв байдал, үг хэл яриа тэргүүтнээр дамжуулан тухайн цаг үеийн хөрөнгөтнүүдийн ашиг орлогын хойноос хэт хөөцөлдөж хувь хүнийхээ үнэт зүйлийг гээн орхигдуулсныг бүх талаар шүүмжлэн, жигшин зэвүүцэж буруушааж байгаа нь бүх зохиолын туршид уншигчдад мэдрэгдэж байдаг. Чухам энэ бол өөрөөр хэлбэл уншигчдад төрж буй тэр сэтгэгдэл бол зохиогчийн далд дуу хоолой юм. Энэхүү зохиогчийн дуу хоолойг зөв мэдэрч, зөв ойлгож тайлбарлах 	
<p>11.16 Зохиолын сэдэв, утга санаа, хам сэдвийн холбоо хамаарлыг тайлбарлах,</p>	<p>А. Сэдэв, утга санаа, хэм сэдвийн холбоо хамаарлыг тайлбарлахдаа:</p> <ul style="list-style-type: none"> - О.Бальзакийн “Эцэг Горио” роман нь түүний бичсэн “Хүн төрөлхтний шог” шүүмжлэлт сэдвийн хүрээнд бичсэн хоорондоо утга үзэл санаа, дэвшүүлсэн асуудлын хувьд холбогддог 60 орчим зохиолын нэг болох талаас нь ойлгож, тайлбарлах - Капитализмын эхэн үеийн энэхүү хүнд хэцүү цаг үед анхны капитал /хөрөнгө/ хуримтлагчдын зэрлэг догшин зан авир, хязгааргүй шунал хүсэл, ёс суртахууны доройтол, бүхнийг “зоосны нүхээр харах” болсноос үүдэлтэй ёс зүй, зан суртахууны уналт доройтол тэргүүтэн нь “Эцэг Горио” зохиолд туссан үндсэн сэдэв болохыг тайлбарлах - Нийгэм түүхийн учир шалтгааныг “Эцэг Горио” зохиолын гол дүр болох баян хөрөнгөтөн Горио өвгөн 	

<p>далд утгыг тайлан тайлбарлах</p>	<p>болон түүний охидуудын дүр, үйл явдал, ёс суртахууны хэм хэмжээ зэрэгтэй холбон ойлгож зөв тайлбарлах</p> <ul style="list-style-type: none"> - Хөрөнгөтний нийгмийн эхэн үеийн капитал хуримтлагчдын шунал хүсэл, увайгүй зан чанар, бүхнийг мөнгө, ашиг орлогоор хэмжиж үздэг Горио өвгөний охидын ёс суртахууны доройтол, хувь хүний дотоод ертөнц нь хэчнээн хүйтэн цэвдэг хүнийссэн байдалтай доройтолд орсныг бусад дүр, үйл явдлын дүр зураглалаар дамжуулан хүүрнэх, тодорхойлох арга барилаар тэрчлэн харилцан яриа зэрэг арга маягийг ашиглан ил шууд бичсэн. Өөрөөр хэлбэл зохиолын утга агуулга, үзэл санаа, дэвшүүлсэн асуудал нь зохиолынхоо гол дүрүүдийн яриа, үйл хөдлөл, үзэл бодол зэргээр шууд дамжин илэрч байгааг тайлбарлах <p>Б. Далд утгыг тайлан тайлбарлахдаа:</p> <ul style="list-style-type: none"> - 19-р зууны үеийн Францын мөнгөний систем, санхүүгийн арга хэрэгсэл, төлбөр тооцооны арга хэрэгсэл /вексел, чек, франк, су гэх мэт/, тэр үеийн хувцаслалт болон хувцасны мода /фрак, скюрток, ...г,м/ мөн түүнчлэн тэр үеийн Парисын гудамж талбай, кафе, үзвэр үйлчилгээ, зам тээврийн хэрэгсэл гэх мэт соёлын элементүүдийг дүрслэн бичсэн үгийн санг зөв ойлгож тайлбарлах <p>Багшид зөвлөх нь <i>Энэ романд эцэг хүний энэрэнгүй сэтгэлийг өгүүлэхээс гадна тухай үеийн Парисын амьдралыг дүрслэн харуулдаг талаас нь сайтар судлахаар даалгаврыг боловсруулах хэрэгтэй.</i></p>	
<p>11.1в. Зохиомжийн бүрэлдэхүүн хэсгүүдийг таньж, утга санаанд хэрхэн нөлөөлж байгааг тайлбарлах</p>	<p>А. Зохиомжийн бүрэлдэхүүн хэсгүүдийг тодруулахдаа:</p> <ul style="list-style-type: none"> - “Эцэг Горио” зохиолд хүүрнэлийн арга, харилцан ярианы арга, хөрөг дүр болон ганцаарчилсан ярианы хэв маяг мөн зохиолын баатруудын өөрсдийнх нь хэл яриагаар зан ааш үзэл бодол, хүсэл эрмэлзэл зэргийг нь тодруулсан тодорхойллын арга маягийг их хэрэглэсэн байдаг нь гол дүрүүдийнхээ нийгмийн байр суурь, дотоод ертөнц, үзэл бодол, хувь хүний ёс зүй, ёс суртахууны түвшин зэргийг тодруулан гаргахад нийцэж тохирсон бүтээлч арга барил болсныг тодорхой жишээ баримтууд дээр иш татан ярьж бичиж сурах - “Эцэг Горио” зохиол нь нийгмийн амьдрал дахь хувь хүн хөрөнгө мөнгө, ёс зүй, ёс суртахууны асуудал зэрэгт анхаарал хандуулсан шүүмжлэлт утга агуулга бүхий зохиол бөгөөд нөгөө талаар энэ роман нь “урбанистическая литература” буюу хотын уран зохиол гэдэг төрөл жанрт хамаарагдах бүтээл бөгөөд үйл явдал нь зөвхөн их хот Парист үйл явдал нь өрнөдөг. Энэхүү учир шалтгааныг тэрчлэн утга сэдвийн болон зохиомж хэл найруулгын онцлог уялдаа холбоог ойлгож тайлбарлах <p>Б. Зохиомжийн онцлог нь зохиолын утга санаанд хэрхэн нөлөөлж байгааг тайлбарлахдаа:</p> <ul style="list-style-type: none"> - Дээр дурдсан зохиомжийн онцлог нь хөрөнгөтний нийгмийг шүүмжлэх, Горио өвгөний дүр буюу бүхнийг мөнгө, эд хөрөнгөөр хэмжин үздэг ёс суртахууны доройтолд орсон капитал хуримтлуулагчдын гэм дутагдлыг дэлгэн харуулахын тулд зөв зохистой, 	

	<p>таарч тохирсон хэл найруулгын арга хэрэгсэл буюу хэлбэр маяг болж чадсаныг мөн л тодорхой жишээ баримтуудыг зохиолын үйл явдал агуулга дундаас сонгон авч тайлбарлах</p>	
<p>11.1г. Зохиолын дүрийн бодгаль ба нийтлэг шинжийг тодорхойлж, зохиолын утга санаанд хэрхэн нөлөөлж буйг тайлбарлах</p>	<p>А. Дүрийн бодгаль ба нийтлэг шинжийг тодорхойлохдоо</p> <ul style="list-style-type: none"> - Горио өвгөний дүр нь нэг талаас Парис хотод амьдардаг өндөр настай бэлбэсэн ганц бие өвгөн бөгөөд том болсон хоёр охинтой, баян франц өвгөн, худалдаачин, мөнгө хүүлэгч, бас ч үйлдвэрлэгч буюу баялаг бүтээгч боловч хувь хүний дотоод эмгэнэлт хувь хүний давтагдашгүй бодгаль дүр гэж ойлгогдож байдаг. Энэ нь ч үнэн. Гэхдээ нөгөө талаасаа энэ хүн бол Горио өвгөн хэмээх ганцхан хувь хүн төдий биш тухайн цаг үеийн буюу анхны капитал хуримтлалын эрин цаг үеийн мянга мянган хөрөнгөтнүүдийн нийтлэг түгээмэл дүр төрхийн нэг төлөөлөл болсон нийтлэг дүр болохыг тодорхойлох <p>Б. Дүрийн шинж нь зохиолын сэдэв, утга санаанд хэрхэн нөлөөлж буйг тайлбарлахдаа:</p> <ul style="list-style-type: none"> - Горио өвгөний заль мэх, гүйлгээ ухаан, нарийн чанд тооцоо, харамч хахир, сувдаг сэтгэл, хатуу ширүүн, энэрэлгүй зан авир тэргүүтэн нь анхны хөрөнгөтнүүд буюу капитал хуримтлуулагчдын хэрхэн яаж баяжиж хөлжсөн түүх, баялаг бүтээсэн түүхэн замналыг зөв ойлгоход тусалдаг. Өөрөөр хэлбэл Горио өвгөний дүр хөрөнгөтний нийгмийн нэг талаараа дэвшилтэт атлаа нөгөө талаараа хүнлэг бус харгис хатуу, энэрэлгүй, хүмүүнлэг бус шинжийг хатуу ширүүнээр илчлэн шүүмжилсэн зохиолын үндсэн утга сэдвийг тодруулахад тусалдаг. Чухам энэ холбоо хамаарлын учир шалтгаан, харилцан шүтэлцээг зөв ойлгож тайлбарлах 	
<p>11.1д. Зохиолын гадаад, дотоод орчин нь дүрийг тодруулахад хэрхэн нөлөөлж буйг тодорхойлох</p>	<p>А. Зохиолын гадаад ба дотоод орчныг тайлбарлан дүгнэхдээ</p> <ul style="list-style-type: none"> - Зохиолын гадаад орчинд тухайн цаг үеийн буюу 19-р зууны Францын нийгэм улс төр эдийн засгийн байдал, 18-р зууны соён гэгээрүүлэгчдийн үзэл бодол, номлол сургаал, 19-р зууны “шүүмжлэлт реализм”-ын үзэл баримтлал, хөгжил зэргийг хамааруулан ойлгож тайлбарлан дүгнэх <p>Б. Зохиолын гадаад ба дотоод орчин нь дүрийг тодруулахад хэрхэн нөлөөлж байгааг ярилцахдаа</p> <ul style="list-style-type: none"> - Зохиолын гадаад орчин /внешние аспекты/ гэдэгт тэр зохиол бичигдэж байх цаг үеийн нийгэм улс төрийн амьдрал, онцлог, философи, тухайн зохиолын утга, зохиогчийн сэтгэлзүйн онцлог, бусад урлагтай тухайн бүтээл хэрхэн холбогдож буй байдал зэргийг хамруулж үзэн тайлбарлах - Дотоод хүчин зүйлс /внутренние аспекты/ болох тухайн зохиолын хэл найруулга, зохиомж байгууламжийн уран чадвар тэргүүтнийг Горио өвгөн болон Растиньак мөн Горио өвгөний охин болох гүнгийн хатан шуналтай хүйтэн сэтгэлт эмэгтэй нарын дүр төрх, ааш авир, үзэл бодол, ертөнцийг үзэх үзэл тэргүүтнийг нь тодруулахад хэрхэн ашигласан зэргийг яг “Эцэг Горио” зохиолоос дундаас нь түүж ашиглах, тайлбарлах үүнийгээ буюу тэрхүү сонгож авсан жишээ баримтуудаа суралцагчид өөр өөрсдийн үзэл бодол ойлголт тайлбар зэргээ чөлөөтэй илэрхийлж, ярьж 	

	<p>бичиж, санал солилцох, мэтгэлцэх зэрэгтээ чөлөөтэй ашиглан үзэл бодлоо илэрхийлэх</p> <p><i>Багшид зөвлөх нь</i></p> <p><i>Гориогийн мөнгө шавхагдсан байв. Эгч дүү хоёр хөрөнгийн талаарх ээлжит нэг хэрүүлийн үеэр Горио ухаан алдаж унан улмаар муудсаар насан эцэслэж байгаа хөөрхийлэлтэй амьдралыг сурагчид ойлгон өөр өөрийн өнцгөөс тайлбар хийж, жишээ баримт татаж, эцэг эхдээ хандаж байгаа хандлага, амьдарч байгаа нийгэм цаг үетэйгээ холбон тайлбарлаж байх нь чухал.</i></p>	
<p>11.1е. Зохиолын найруулга нь утга санаанд хэрхэн нөлөөлж буйг тодорхойлох</p>	<p>Зохиолын найруулгыг судлахдаа:</p> <p>–Энгийн ярианы хэл найруулга, хүүрнэл хэлбэрийн өгүүлэмжийг голлон ашигласан. Мөн тэрчлэн 19-р зууны үеийн Францын мөнгөний систем, санхүүгийн арга хэрэгсэл, төлбөр тооцооны арга хэрэгсэл /вексел, чек, франк, су гэх мэт/, тэр үеийн хувцаслалт болон хувцасны мода /фрак, скюрток, ...г,м/ мөн түүнчлэн тэр үеийн Парисын гудамж талбай, кафе, үзвэр үйлчилгээ, зам тээврийн хэрэгсэл гэх мэт соёлын элементүүдийг дүрслэн бичсэн үгийн сан, хэл найруулгын хэв шинж зэрэг нь “Эцэг Горио” зохиолын хэл найруулгын өвөрмөц онцлогийг тодорхойлдог бөгөөд чухам энэ онцлог нь дээр дурдсан зохиолын үндсэн утга агуулга, шүүмжлэлт сэдэв утга, санааг тодруулахад яв цав нийцэж зохиолын агуулгыг итгэл үнэмшилтэйгээр илэрхийлж чадсан болохыг ойлгож ухамсарлаж, тэдгээрийг шүүн хэлэлцэх</p>	
<p>11.1г. Шүүмжийн санаа, шүүмжлэгчийн үнэлгээ, дүгнэлтийг тайлбарлах</p>	<p>Зохиолд өгсөн дараах хүмүүсийн үнэлгээ, шүүмжийг яагаад гэдгийг ойлгож, учир шалтгааны үүднээс тайлбарлах.</p> <p>–Германы эрдэмтэн К.Марксын хэлснээр Бальзак “Бодит харьцааг гүн ойлгосон” гайхамшигт зохиолч байв.</p> <p>–Ф.Энгльс, Бальзакийн “Хүн төрөлхтний шог” бүтээлийг уншаад “Францын нийгмийн бүх түүхийг цогцлуулан бичсэн... энэ номоос би эдийн засгийн тодорхой зүйлийн хувьд ч гэсэн (жишээ нь хувьсгалын дараа бодит ба хувийн өмчийг дахин хуваарилсан тухай) тэр үеийн бүх мэргэжилтэн түүхч, эдийн засагч, тоо бүртгэгчдийн номыг бүгдийг хамтад нь уншсанаас илүү их зүйлийг мэдэж авсан билээ” гэж эдийн засаг, нийгмийн байдлыг өргөн дэлгэр реалист дүр дүрслэлээр маш зөв гаргасныг тэмдэглэснийг ухаарч ойлгон уншаад тайлбар хийж байвал зүгээр.</p>	

Оросын романаас судлах

Суралцахуйн зорилт	Үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p>11.1а. Оросын шилдэг романаас уншиж, зохиолын хамсэдвийн хүрээнд тусган эргэцүүлэх, үзэл бодлоо илэрхийлэх</p>	<ul style="list-style-type: none"> А. Түүх, нийгэм, соёлын хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэхдээ: Энэхүү алдарт гурамсан роман нь өнгөрөгч 20- р зууны 30-аад онд өнөөгийн Орос орон буюу тэр үеийн нэрээр ЗХУ-д оршин тогтнож байсан ганц хүний дангаар ноёрхох тоталитари төрийн засаглал ямар аймшигтай, шударга бус, харгис, хүний эрх эрх чөлөөг өчүүхэн ч хайхардаггүй зэрлэг балмад, хүмүүнлэг бус дэглэм байсныг түүх-нийгэм-соёлын өргөн дэвсгэр дээр нүдэнд харагдтал яруу сайхан дүрслэн илэрхийлсэнийг ойлгох Тэрчлэн түүхийн болон нийгэм судлалын үүднээс нэг хүний дангаар дарангуйлан захирах тоталитар дэглэм гэж юу болох, ардчилал, хүний эрх, эрх чөлөө хэмээх хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлс ямар ялгаатай хоорондоо 	<p>А.Рыбаков “Арбатынхүүхдүүд”, “Айдас” “Үнс чандруу”</p>

	<p>хэрхэн зөрчилддөг болохыг энэ зохиолын уран сайхны дүр, үйл явдлын өрнөлийн дагуу ойлгох</p> <ul style="list-style-type: none"> • Сталинизм бол нэг хүний дангаар ноёрхох тоталитар дэглэм ямар аймшигт алдаа завхралд хүргэж болдогийг харуулсан ба нэг хүнийг тахин шүтэх үзэл хэрхэн эхэлж, хэрхэн даамжирч, улмаар хууль ёс хэрхэн гажуудаж, олон түмний санал бодол, хамтын удирдлагын зарчим хэрхэн алдагдаж, ямар ч үнэ цэнгүй болдог тухай энэхүү зохиолын үйл явдал, дүр дүрслэлээр дамжуулан нүдэнд харагдтал өгүүлснийг ойлгох • Улс орны бүх эрх мэдэл зөвхөн нэг хүний гарт төвлөрч бусад нь түүнд үг дуугүй захирагддаг тогтолцоо хэрхэн үүсэж бэхэжсэн түүхийг “Арбатын хүүхдүүд” роман сонгодог их туульсын хэмжээнд дүрслэн хүүрнэж чадсан билээ. • - Тоталитари дэглэм гэдэг нь нэг хүний дангаар ноёрхох хэмжээлшгүй эрхт төрийн мөн чанарыг тодорхойлдог нэр томъёо. И.В.Сталины засаглал бол чухамдаа түүхэнд төрөн гарсан тоталитари дэглэмийн сонгодог жишээ юм. Тэрээр төрийн эрх барьж байхын тулд намын болон төр засгийн нэр барьж, социализм, коммунизмын сургаалыг бамбай болгон дураараа дургих, өөрийн зам дахь өрсөлдөгчдөө зайлуулах, устгах, ард түмнээ хэлмэгдүүлэх, хүний амь нас, хувь заяаг өчүүхэн ч үл бодох болсон бөгөөд ганц өөрийгөө бүхий л улс орон лугаа адил адилтан өргөмжлөх болсноор аймшигт хэлмэгдүүлэлт, гунигт хувь тавилан, өгүүлшгүй зовлон бэрхшээлийг эх орон ард түмэндээ авчирсан буруутан болсон билээ. Өөрийнх нь алдаатай гадаад бодлогын улмаас дайны эхний саруудад аймшигт ялагдал хүлээж байх үедээ бодож буй “...бас ард түмэн ТҮҮНД сөгдөж байна.ТҮҮНД сөгдсөн хоёр зуун сая хүн. Минскээс Москва хүртэлх бүх замыг энэ сая сая хүний биеэр чигжинэ...Энэ бол сая сая хүний, живаа живаа хүний цус байх болно. Хэрэв ТЭРЭЭР амь эрсдэх тавилантай бол, ТЭРЭЭР ганцаараа эрсдэхгүй. Бүх ард түмэн ТҮҮНТЭЙ хамт эрсдэнэ. Нэг ч хүн үлдэх ёсгүй.” гэж бодож байгаа бодлоос нь тэрээр ямар аймшигтай харгис, ард түмнээ гэх өчүүхэн ч сэтгэлгүй, хэрцгий догшин хүн болох нь тодорхой харагддаг. Чухам энэ бүхнийг уншиж, ойлгож, ухамсарлаж, дүр дүрслэл, хэл найруулга, зохиомж байгууламжийнх нь уран чадварыг бадан бишрэх нь суралцагчдын уран сайхны боловсрол эзэмшинэ. <p>Б. Үзэл бодлоо илэрхийлэхдээ:</p> <ul style="list-style-type: none"> • Энэ романы сэдэв өгүүлэмжээр дамжин илэрсэн утга санааг өнөөгийн өөрсдийн амьдран буй цаг үе, нийгэм түүхийн онцлогтой холбон тайлбарлах, тэдгээрийн хоорондын ялгаа зөрүүг өөрсдийн үнэлгээ, итгэл үнэмшлийн үүднээс тайлбарлах, илэрхийлэх чадвар суралцахуйн бас нэгэн нэн тэргүүний прагматик зорилт мөн. Нэг хүний дангаар ноёрхсон авторатар дарангуйлагч төр болон чөлөөт нээлттэй хүмүүнлэг ардчилсан нийгмийн засаглалын зааг ялгааг тодруулах, энэхүү чанарын ялгааг ойлгож ухамсарлах, тэрхүү ойлгож авсан уран сайхны түүхээ /энэхүү романы утга агуулга, дүр дүрслэл, уран сайхны чадварыг гэсэн үг/ өөрсдийн хувийн итгэл үнэмшил, иргэний боловсролын үнэт зүйл болгон төлөвших нь А.Рыбаковын “Арбатын хүүхдүүд” гурамсан романыг 	
--	---	--

	<p>уншиж судлахын бас нэгэн суралцахуйн зорилт, үзэл бодлын үнэт төлөвшил мөн.</p> <ul style="list-style-type: none"> • Суралцагчид өнөөгийн чөлөөт ардчилсан нээлттэй нийгмийн үнэт зүйлсийг өнгөрсөн үеийн түүхийн аймшигт хатуу ширүүн тоталитар дэглэмтэй харьцуулан шүүмжилж, амьдран буй цаг үеийнхээ үнэт зүйл болох хүний эрх эрх чөлөө, ардчилалыг цаг ямагт хайрлан хамгаалж, дээлэн эрхэмлэж, улам бүр боловсронгуй болгон төгөлдөржүүлж байхын чухлыг энэхүү зохиолын агуулга үйл явдлын өрнөл дундаас тохирсон жишээ баримтуудыг чөлөөтэй иш татаж өөрсдийн үгээр өөрсдийн итгэл үнэмшлээр жишээ баримттайгаар илэрхийлэн ярьж сурах нь өөрөөр хэлбэл дээр дурдсан нийгэм – түүхийн сэдвээр хувийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж сурах нь суралцагчдын чухал зорилт байх болно. 	
<p>11.16. Үйл явдлын шугам хийгээд хүүрнэлийн учир холбогдлыг тодорхойлж, дуу хоолойг тайлбарлах</p>	<p>А. Үйл явдлын шугам хийгээд хүүрнэлийн учир холбогдол: – “Арбатын хүүхдүүд” роман нь үйл явдлын олон шугамтай, утга агуулгын олон давхраатай, бүтцийн хувьд гурван дэвтэр туульсын том хэмжээний хүүрнэл хэлбэрийн бүтээл буюу туульсын роман юм. Юуны өмнө роман нь тоталитар төрийн онцлог, мөн чанарыг илэрхийлэн харуулах зорилготой И.В.Сталины дүр, дотоод бодол, дурсамж, хувийн итгэл үнэмшил, зан чанар, үзэл баримтлал, ертөнцийг үзэх үзэл болон түүний эргэн тойронд Кремлийн албан тасалгаанд голчлон өрнөж буй үйл явдлын нэг шугам зохиолын уран сайхны гол дүрийн нэг болох Саша Панкратовын амьдрал хувь заяагаар төлөөлүүлэн үзүүлж буй тухайн цаг үеийн эгэл жирийн хүмүүс залуу үеийн эмгэнэлт түүхийг дүрслэн харуулсан бас нэгэн шугам гэсэн үйл явдлын ийм үндсэн хоёр том шугамтай бөгөөд энэ хоёр шугам нь дотроо зохиолын агуулга, утга санаа, дэвшүүлсэн асуудлыг илэрхийлэхэд зориулагдсан олон дэд шугамд хуваагддаг. Романы уран сайхны бүтэц байгууламжийн энэхүү онцлогийг ойлгож ухамсарлах, дэд шугам бүрийн үйл явдал болон утга санааг ойлгож ухамсарлах тэдгээрийн хоорондын уялдаа холбоог зөв тогтоож зохиолын үндсэн утга санаанд тэдгээр нь хэрхэн холбогдож, нэгэн цул нэгдэл, уран сайхны гайхамшигт дүр зураглал болон хувирч буйг тайлбарлах чадвар дадлыг эзэмших явдал нь суралцагчдын уран сайхны боловсролын нэг чухал зайлшгүй эзэмшвэл зохих суралцахуйн зорилт болно.</p> <p>Б. Хүүрнэлийн дуу хоолойг тайлбарлахдаа: -- Уламжлалт нэр томъёогоор зохиогчийн үг яриа буюу өөрийн хүүрнэл, 1-р биеэс хүүрнэн ярих, тайлбарлах зохиомжийн арга энэ романы бүх хэсгүүдэд дагалддаг. Романы агуулгын ар талд хүүрнэл хэлбэрээр бичигдсэн энэ арга маяг нь нэн ялангуяа “Айдас” хэмээх 2-р дэвтэр дээр түүх, архив, тухайн цаг үеийн сонин хэвлэл, тушаал, зарлиг, тогтоол гэх мэт баримтат бичлэгийг шууд хуулбарлан оруулсан хэлбэрээр их тохиолддог бөгөөд үүнийг романы хэвлэлд үсгийн шрифтийг өөрчлөх аргаар тодруулсан байдаг. /тодруулах, шрифтийг налуулах, үсгийн фонтийг өөрчлөх г,м/ -- хүүрнэлийн дуу хоолой гэсэн тодорхойгүй энэ нэр томъёог заавал хэрэглэнэ гэвэл зохиолыг уншиж буй үед тухайн текстээс уншигчдад мэдрэгдэж буй зохиогчийн</p>	

	<p>бичлэгтээ шингээх гэж эрмэлзсэн тэр өнгө аяс /тональность/ юм. Романыг уншихад ялангуяа төгсгөлийн 3-р дэвтэр болох “Үнс чандруу” романы бичлэг болон нийт романы төгсгөлөөс уншигчдад төрж буй харуусал, харамсал, уй гуниг, сэтгэлийн зовлон, дарамт тэр бүхэн зохиолын бүхий л өрнөлийн явцад байнга мэдрэгдэж байдаг тэр мэдрэмж мөн. Өөрөөр хэлбэл зохиолын турш дагалдаж түүний бичлэг хэл найруулга дүр дүрслэл тэргүүтэнд шингэсэн далд өнгө аясыг энэ нэр томьёонд хамааруулж ойлгоно.</p>	
<p>11.16. Зохиолын сэдэв, утга санаа, хам сэдвийн холбоо хамаарлыг тайлбарлах, далд утгыг тайлан тайлбарлах</p>	<ul style="list-style-type: none"> – А. Сэдэв, утга санааг, хэм сэдвийн холбоо хамаарлыг тайлбарлахдаа: – Энэ бол түүх нийгмийн сэдэвтэй уран сайхны зохиол. – Нэг хүний дарангуйлал тогтсон тоталитар дэглэм, түүний хор уршиг, мөн чанарыг шүүмжилсэн сэдэв романы үндсэн сэдэв буюу дэвшүүлсэн асуудлын ноён нуруу нь юм. – 1930-аад оны хэлмэгдүүлэл Орос оронд болон дэлхий дахинд ямар их уй гуниг, хор уршиг авчирч коммунизмын үзэл санаа шууд ба шууд бус утгаараа 100 000 000 хүн амь насаа алдсаны нийгэм- түүхийн учир шалтгаан юу болох – Бүхэл бүтэн улс үндэстэний түүхэн хувь заяаны тухай эргэцүүлэл, хувь хүн болон нийгэм дэх айдас аливаа дарангуйлагч тогтолцоог өсөж бэхжих нэг үндэс болдогийг харуулсан явдал мөн энэхүү зохиолын бас нэгэн сэдэв. – Дэлхийн 2-р дайныг өдөөсөн гол гэмт хэрэгтнүүдийн нэг нь чухамдаа Сталин тэргүүтэй анхны социалист улс болох тэр үеийн ЗХУ байсан тухай шүүмжлэл – Аугаа Их Эх Орны дайнд ЗХУ яагаад тийм аймшигтай хохирол амсаж 27 000 000 хүнээ алдсаны жинхэнэ цаад учир шалтгаан юу байсан бэ? – Социализм, коммунизм нь фашизмтай хүйн холбоотой бөгөөд хүний эрх чөлөөг уландаа гишгэсэн харгис хэрцгий хүнлэг бус байдлаараа адил төстэй болохыг шүүмжилсэн явдал – Хайр сэтгэл, мөнхийн залуу насны романтик тэмүүлэл, нэгэн үеийн залуусын эмгэнэлт хувь заяа – Хүний сайхан сэтгэл, ёс зүй, ёс суртахуун, дотоод ертөнцийн ариун нандин байдал, хүнлэг үзэл санаа ямар ч үед нугардаггүй тухай – Үерхэл нөхөрлөл, шударга ёсыг магтан дуулсан тухай тэрчлэн хувь хүний бэртэгчин үзэл санаа, аминч үзлийг шүүмжилсэн нь зэрэг олон арван сэдвүүдийг нийгэм, түүхийн хичээл дээр эзэмшсэн мэдлэг мэдээлэлтэйгээ холбон ойлгож ухамсарлах, амьдрал үзэл санааны итгэл үнэмшил болгон дагаж мөрдөх, өнөөгийн олон ургальч нийгэмд хүн төрөлхтний нийгэм- түүх- улс төрийн болон ёс зүй- ёс суртахууны нийтлэг үнэт зүйлсийг дээдлэн хүндлэх үзэл санаагаар хувь хүн төлөвшихөд энэхүү их туульсын зохиолын утга агуулга, сэдэв үзэл санааг бүтээлчээр холбон ашиглах чадвар дадлыг эзэмших нь суралцахуйн нэг зорилт мөн. – Б. Далд утгыг тайлан тайлбарлахдаа: – Аливаа муу юм гэдэг угаас хүний өөрийнх нь мөнхийн төрөлхийн заяамал шинж /аутентик/ гэсэн 19-р зууны Оросын их сэтгэгч, зохиолч Ф.М.Достоевскийгээс улбаатай үзэл санаа үе үе цухалздаг. 	

	<p>– Мөн 20-р зууны Орос орны хувь заяанд тохиолдсон аймшигт эмгэнэл нь Орос хүний өөрсдийнх нь унаган төрх болох ... шинж, зан төрх, үзэл санааны бэртэгчин байдлаас улбаатай гэсэн үзэл санаа бас үе үе илэрдэг.</p>	
<p>11.1в. Зохиомжийн бүрэлдэхүүн хэсгүүдийг таньж, утга санаанд хэрхэн нөлөөлж байгааг тайлбарлах</p>	<p>– А. Зохиомжийн бүрэлдэхүүн хэсгүүдийг тодруулахдаа: – Зохиомжийн үндсэн бүрэлдүүлбэр нэгжүүд болох хүүрнэлийн арга, хөрөг дүр болон тодорхойллын арга, захидал харилцаа, байгалын зураглал, ганцаарчилсан яриа болон дотоод сэтгэлийн өчиг тэрчлэн зохиогчийн тэмдэглэл, харилцан ярианы арга зэрэг бичлэг найруулгын хэв маягууд энэ зохиолын өгүүлэмжийн туршид ашиглагдсан. Тэр бүгдийг зохиогч өөрийн гаргах гэсэн утга агуулга, сэдэв, өгүүлэмж, дэвшүүлсэн асуудлуудтайгаа холбон хэрхэн зөв сонгон найруулж, уран сайхны дахин давтагдашгүй туурвил бүтээж чадсаныг романы аль ч хэсгээс чөлөөтэй иш татан тайлбарлаж ярьж сурах нь суралцахуйн практик зорилт, амьдралын олон тохиолдолд /уран сайхны өөр бусад текстүүд дээр ажиллах төдийгүй, захидал харилцаа, албан бичиг, эссе, тайлан бичих, аливаа тохиолдолд өөрийн хувийн байр суурь, итгэл үнэмшил, санаагаа аман болон бичгийн хэлбэрээр зөв, яруу, эмх цэгцтэй, ойлгомжтой илэрхийлж сурах хэрэглээний /утилитарный/ зорилтуудын нэг мөн.</p> <p>– Б. Зохиомжийн онцлог нь зохиолын утга санаанд хэрхэн нөлөөлж байгааг тайлбарлахдаа: -- Энэ зохиолын 1-р дэвтэр болох “Арбатын хүүхдүүд” романд уран сайхны энгийн реалист дүрслэлүүд болох хүүрнэл болон харилцан яриа тэрчлэн хөрөг дүрийн аргуудыг голчлон ашигласан байдаг нь Сталин, Молотов, Черчиль болон Гитлер г.м тэр үеийн бусад түүхэн хүмүүстэрчлэн 1930-аад оны Москва, тэр цаг үеийн залуусын дүр төрх, нийгэм түүхийн зөрчил тэмцэл зэргийг тодруулан танилцуулахад тохиромжтой байсан бол зохиолын 2 – р дэвтэр болох “Айдас” романд түүхэн тоо баримт, сонин хэвлэлийн мэдээ мэдээлэл, улс төр дипломатын болон тагнуул, цагдаа, нууц алба зэрэг тусгай албадын мэргэжлийн үйл ажиллагаа зэргийг дүрсэлсэн нийтлэлийн хэл найруулгыг мэргэжлийн үг яриа, хэл найруулга зэрэгтэй сүлэлдүүлэн идэвхтэй ашигласан нь 1930-аад оны аймшигт хэлмэгдүүлэлтийн нийгэм түүхийн үндэс шалтгаан уг сурвалжийг тодруулах, тэр цаг үеийн гунигт хар бараан амьдрал хувь заяаны эмгэнэлт утга агуулгыг тодруулахад зохимжтой арга болсон бол энэ бүтээлийн төгсгөлийн 3-р дэвтэр болох “Үнс чандруу” романд цэрэг дайны болон дипломат албаны мэргэжлийн нэр томьёо, харилцан яриа, хүүрнэл голлон жишээ нь байгалын зураглалын арга маяг бараг огт ашиглагдаагүй зэрэг нь бүх нийтээрээ айдаст автсан дарангуйлагч төрийн дор амьдарч буй ард түмний зовлон зүдгүүр, эрх чөлөөгүй байдал болон дэлхийн 2-р дайны түүхийг өгүүлсэнтэй холбоотой бөгөөд туульсын романы эмгэнэлт утга санаатай зохицож нийцэж байгаа юм. Чухам энэ бүхнийг жишээ баримтаар тайлбарлах чадвар дадлыг эзэмших нь суралцахуйн зорилтын нэг салшгүй хэсэг болно.</p>	
	<p>А. Дүрийн бодгаль ба нийтлэг шинжийг тодорхойлохдоо -- А.Рыбаков нь үнэхээр сонгодог зохиолчийн энд хүрсэн суу билигт уран бүтээлч учраас бүх л дүрүүд дээр ярьж болно. Жишээ нь : И.В.Сталин гэхэд л намхан нуруутай,</p>	

<p>11.1г. Зохиолын дүрийн бодгаль ба нийтлэг шинжийг тодорхойлж, зохиолын утга санаанд хэрхэн нөлөөлж буйг тайлбарлах</p>	<p>цоохор нүүртэй, гүрж үндэстэн, мэргэжлийн хувьсгалч, аймшигтай харгис үзэл бодолтой, томоохон улс төрч 1881-1953 оны хооронд амьдарч байсан Зөвлөлтийн нам төрийн эрхийг барьж байсан нэг талаараа дахин давтагдашгүй бодгаль хувь хүн харин нөгөө талаараа дэлхийн түүхэнд цөөнгүй гарсан Гитлер, Муссолини, Мао Цзе Дун, Саддам Хусейн г,м олон арван дарангуйлагч улс төрчдийн нийтлэг дүр төрх гэж хэлж болно. Романы гол дүр Саша Панкратов нь нэг талаараа сайхан сэтгэлтэй, эрэлхэг зоригтой, шударга шулуун, боловсролтой, хүнлэг энэрэнгүй үзэл санаатай, гэнэн романтик залуу бөгөөд ээжтэйгээ хамт Москвагийн Арбатын гудманд амьдардаг, түүх сонирхдог, Тээврийн дээд сургуулийн төгсөх курсэд суралцдаг оюутан залуу хожим 1943 оны 7-р сард Курскийн дэргэдэх тулалдаанд баатарлагаар амь үрэгдсэн хувийн эмгэнэлт намтар түүхтэй бодгаль залуугийн дүр гэтэл нөгөө талаараа бол Саша тэр үеийн хэлмэгдэж зовсон хөөрхий Орос орны сая сая залуусын нэг дээр дурдсан дайнд амь үрэгдсэн 27 000 000 хүний төлөөлөл нийтлэг нь болсон дүр билээ. Үүнийг Оросын болон Монголын түүхийн эмгэнэлт цаг үеийн түүхэн баримтуудтай холбон ойлгож тэдгээрийн нийтлэг ба тодорхойн шинжийг ойлгон ухамсарлаж, тайлбарлаж сурах нь суралцахуйн зорилтын нэг мөн.</p> <p>Б. Дүрийн шинж нь зохиолын сэдэв, утга санаанд хэрхэн нөлөөлж буйг тайлбарлахдаа:</p> <p>- Варя Ивановнагийн дүр бол энэ зохиолын хамгийн яруу сайхан, харамсалтай - эмгэнэлт хувь тавилан бүхий, хайрлан дурсмаар дүр. Гэнэн хонгор, хүүхэд наснаасаа эхлэн амьдралын хүнд хэцүү аймшигт сорилт шалгалт дунд хүнлэг сэтгэл, хүний ёс жудагтай байж чадсан, эр зориг, өрөвч сэтгэл, хатуу зан араншин хослуулсан, шударга ёсны дуулал болсон гайхамшигтай дүр. Хэзээ ч өөрийгөө буюу амин хувийн өчүүхэн эрх ашигаа бодож яваагүй харамсалтай богинохон насандаа муу муухай бүхнийг үнэн сэтгэлээсээ жигшин зэвүүцэж, хүнлэг ёсны гэрэл гэгээнд зүрх сэтгэлээсээ тэмүүлж яваад 27- хон насандаа төрөлх эх орныхоо төлөө амь насаа алдаж буй энэ бүсгүйн дүр бол Оросын уран зохиол дахь А.С.Пушкины “Евгений Онегин” романы Татьяна, А.С.Тургеневийн “Ася” зохиолын Ася, Л.Н.Толстойн “Дайн ба Энх” романы Наташа Ростова нарын нэгэн адил Орос эмэгтэйн хамгийн яруу сайхан, хайрлам дүрүүдийн нэг билээ. Тэрээр өөрөө ч бараг хүүхэд наснаасаа салаагүй шахам цэл залуу 19-хөн настай байхдаа аюул ослыг мэдсээр байж огтхон ч үл хайхран, өчүүхэн ч эргэлзэж тээнэгэлзэх сэтгэлгүйгээр зовлонд учирсан Лена Будягинад туслан балчир хүүгий нь өөрийнхөө нэр дээр шилжүүлэн авч, улмаар алс дорнодод сууж байсан төрсөн эгч Нина Ивановна, түүний нөхөр Максим Костин нарт хүргэж өгсөнөөр гарцаагүй аюулаас зайлуулж чаддаг. Нэгэн удаа дайны хүнд бэрх цагт өөрийн хүнсний нормыг өндөр настай өвгөн эмгэн хоёрт бүгдийг нь үлдээгээд хэзээ ч эргэж ирэхгүйгээр явах үед нь тэрхүү хоёр хөгшин түүнийг хайрлан өрөвдсөндөө өөрийн эрхгүй бурханд даатган, араас нь загалмайлан адислаж байдаг. Өөрийгөө бус зөвхөн бусдын сайн сайхны төлөө бие сэтгэлээ зориулна гэдэг хэлэхэд амархан боловч амьдрал дээр хэн хүн хийж чаддаг үйлс огтхон ч биш билээ. Зөвхөн</p>	
--	---	--

	<p>гэгээн хутагтууд, аугаа их ёс зүй, аугаа их өрөвч нинжин сэтгэл, аугаа их ёс суртахууны өндөр дээд төвшиний хүн л гагцхүү ингэж чаддаг. Варя чухам ийм хүн байсан учраас бурхан тэнгэрт огтхон ч үл итгэдэг, шашингүйн үзлээр хүмүүжсэн Лена Будягина хүртэл нэг удаа Саша Панкратовт “тэр бол гэгээнтэн хүн” гэж өөрийн эрхгүй, хүндлэн хайрлах сэтгэлийн угаас сүслэн хэлж байдаг билээ. Чухам ийм яруу сайхан сая сая охид хөвгүүдийг хэлмэгдүүлж, амь насыг нь үрсэн шууд буруутан бол тэр үеийн Сталины тоталитар дэглэм, тэр үеийн коммунист үзэл санаа гэдгийг ойлгож ухамсарлах нь л энэ аугаа их зохиолыг уншиж судлахын хамгийн гол ач холбогдол, суралцахуйн зорилго гэж хэлж болно.</p>	
<p>11.1д. Зохиолын гадаад, дотоод орчин нь дүрийг тодруулахад хэрхэн нөлөөлж буйг тодорхойлох</p>	<p>А. Зохиолын гадаад ба дотоод орчныг тайлбарлан дүгнэхдээ -20-р зууны эхэн үеийн дэлхий дахины тэр тусмаа Орос орны түүх, дэлхийн 2-р дайн болон АИЭОДайн, А.Рыбаков хэмээх суу билигт зохиолчийн амьдрал уран бүтээлийн хувь зая, туулсан замнал, үзэл бодлын төлөвшил, ардчилал ба дарангуйллын тухай ойлголт ухагдахуун, зохиолын үзэл санаа, утга агуулга зэрэг нь энэ зохиолын гадаад талын хүчин зүйлс болно. Харин дотоод тал нь энэ зохиолын хэл найруулга, зохиомж байгууламж, бүтцийн онцлог, төрөл зүйлс зэрэг туурвилзүйн тал нь бүгд орно. Б. Зохиолын гадаад ба дотоод орчин нь дүрийг тодруулахад хэрхэн нөлөөлж байгааг ярилцахдаа -- Энэ бүхэн “Арбатын хүүхдүүд” зохиолын бүх дүрүүдийг амилуулж бүтээж буй болгож буй шууд нөлөө мөн. Энэ бүхэнгүйгээр энэ зохиолын нэг ч дүр амилахгүй байсан билээ.</p>	
<p>11.1е. Зохиолын найруулга нь утга санаанд хэрхэн нөлөөлж буйг тодорхойлох</p>	<p>Зохиолын найруулгыг судлахдаа: –Түүхэн баримтуудыг уран сайхны хэл найруулгатай хольж сүлэлдүүлсэн нь энэ романы хэл найруулгын нэг онцлог. Найруулгын энэ арга нь 20-р зууны эхний хагасын Орос орны амьдрал ялангуяа 1930-аад он болон 1941-1945 оны эх орны дайны гунигт хувь тавиланг ойлгож ухамсарлах, тэрхүү эмгэнэлт байдалд хүргэсэн тоталитар дэглэм болон коммунист үзэл санааг хурцаар шүүмжилсэн зохиолчийн санааг маш тод томруун болгон товойлгон харуулахад маш их зохимжтой арга болж уншигчдийг зохиолын утга санааны аймшигт үнэнд итгүүлж үнэмшүүлж чадсан байна. Үүнийг зохистойгоор жишээ татан тайлбарлах чадвар эзэмших нь суралцахуйн зорилтын нэг мөн.</p>	
<p>11.1г. Шүүмжийн санаа, шүүмжлэгчийн үнэлгээ, дүгнэлтийг тайлбарлах</p>	<p>А. Утга шилжүүлэн дүрсэлсэн үг хэллэгийг таних, үндсэн утгаас шилжсэн ямар утга гарч байгааг ажиглах Б. Зохиолын хэл яриаг илүү үр дүнтэй болгохын тулд хэрэглэсэн уран дүрслэл ба яруу хэрэглүүрийн хэрэглээг шинжлэх -Романы 1-р дэвтэрт Варя нэг хөвгүүнтэй утсаар танилцдаг тухай хэсэг ганцхан удаа цухас гардаг. Утсаар танилцсан учраас хэн нь ч хэнийгээ хараагүй ямар хүүхдүүд болохоо огт мэдэхгүй бас тэгээд мэдээж уулзахгүй юм чинь зүгээр л уйдахаараа цаг нөхцөөж уулзахгүй юм чинь гээд чөлөөтэй ярьцгаадаг. Хөвгүүн утасдах болгоно доо - Хүүе Наташа чамайг нээрэн хэн гэдэг юм бэ? гэж асууна. Варя ч мэдээж намайг Наташа л гэдэг...тэгээд л чиний нүд ямар вэ гэх мэтээр 16-тай</p>	

	<p>хүүхдүүд ярина. Варя хариулж байна – “Миний нүд цэнхэр тэгэхдээ захаараа улаан шаргал ! – Хөвгүүн айх шахам гайхаад – Пэ тийм нүд гэж байх уу? “ Энэ бүхэн бол үнэхээр л гэнэн балчир өсвөр насны хөвгүүд охидын яриа шүү дээ !!! Том хүмүүс хэзээ ч ингэж ярихгүй билээ. Чухам ийнхүү хамгийн өчүүхэн дүрслэл хэдхэн өгүүлбэр нь хүртэл үнэхээр л цаад дүрүүдээ нүдэнд харгдтал бичсэн байдаг. Энэ хөвгүүн зохиолд дахиад хэзээ ч гардаггүй билээ.</p> <p>В. Бичил дүрслэлийн хэрэглээг тайлбарлах -Зохиолын төгсгөл хэсэгт дайны үед 1943 оны 7-р сард нэг удаа Варя түр сууж байсан айлаасаа гаран анги руугаа явж байгаад санамсаргүй эргэж хартал хойноос нь хараад зогсож байсан эмгэн түүний араас загалмайж байгаад түүнийг эргэж хармагц гар нь хөшчихсэн гэж гардаг. Энэ бяцхан дүрслэлд л гэхэд Варя хатуу чанга зантай, зөрүүд, эрэмгий, зоригтой эршүүд хүн боловч үнэхээр ямар гайхамшигтай хүнлэг энэрэнгүй, бүх хүний хайр хүндэтгэлийг татсан ёстой л нэг удаа Лена Будягинагийн хэлсэн “Тэр бол гэгээнтэн” гэж хэлсэн үгийг батлах шиг болдог. 26-хан настай залуу бүсгүйг хэзээ ч хэн ч “гэгээнтэн” гэж хэлэхгүй, үнэхээр зохимжгүй, гэтэл энэ зохиолд энэ гуравхан үг Варягийн дүрд үнэхээр нийцдэг билээ !!! Бас тэр настай эмгэний араас нь загалмайлан ерөөж буй байдал !!!</p>	
--	---	--

Суралцахуйн зорилт	Үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p>11.1а. Өрнөдийн модернист зохиолоос уншиж, зохиолын хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэх</p>	<p>А. Түүх, нийгэм, соёлын хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэхдээ: -20-р зууны 70-аад оны үеийн Оросын сюрреалист уран зохиолын хамгийн том төлөөлөгчийн нэг нь В.Ерофеев болон түүний “Москва – Петушки” хэмээх үргэлжилсэн үгийн хэлбэрээр бичигдсэн уянгын яруу найргийн бүтээлийг гэж үздэг. Энэ зохиол нь мөнхийн гүн мансууралд орж архины хүнд хэлбэрийн хамааралтай болсон гол дүр болох Венягийн өчил, үглэл, сэтгэлийн хөөрөл – саатал, цагаан солиорол, согтуурал, мансуурлыг дүрсэлсэн ил үйл явдалтай боловч “время – застоя” /”зогсонги үе”/ гэж нэрлэгддэг тухайн цаг үеийн Орос орны /тэр үеийн нэрээр ЗХУ/ нийгэм дэх гүн хямрал, үзэл суртал, нийгэм, улс төр, эдийн засгийн дампуурлыг хурцаар элэглэн шүүмжилсэн хошин шог хэтрүүлгийн аргаар бичигдсэн зохиол гэдгийг зөв ойлгож ухамсарлах нь суралцахуйн үндсэн зорилт мөн.</p> <p>Б. Үзэл бодлоо илэрхийлэхдээ: –Авьяаслаг, өндөр боловсролтой, ариун шударга сэтгэлтэй, эгэл жирийн ажилчин хүн яагаад тухайн цаг үедээ өөрийн амьдран буй нийгэмдээ гадуурхагдсан бэ? Зохиолын гол дүр Венягийн архинд орж, амь амьдралаа алдсаны цаад гол буруутан нь хэн бэ? Зохиолд гарч буй сахиусан тэнгэрүүдийн дүр ямар учир утгыг илэрхийлж байна вэ гэдэг талаар өөрсдийн бодол сэтгэгдлээ илэрхийлж, дүн шинжилгээ хийх, нийгэм болон хувь хүн хоёрын хоорондын хамаарал зохиролын тухай В.Ерофеевын дэвшүүлж буй санааг шүүмжлэн хэлэлцэж, мэтгэлцээн өрнүүлэх чадвар дадал эзэмших нь суралцахуйн нэг зорилт мөн.</p>	<p>В.Ерофеев “Москва - Петушки”</p>
	<p>А. Үйл явдлын шугам хийгээд хүүрнэлийн учир холбогдол:</p>	

<p>11.16. Үйл явдлын шугам хийгээд хүүрнэлийн учир холбогдлыг тодорхойлж, дуу хоолойг тайлбарлах</p>	<p>Б. Хүүрнэлийн дуу хоолойг тайлбарлахдаа: – “Москва – Петушки” зохиолд үе үе дүрслэгдэж буй сахиусан тэнгэрүүдийн дүр болон Библи судрын ариун мөрүүдийг ишлэн сануулж байдаг хэсгүүд нь энэ зохиол дахь хүүрнэлийн дуу хоолой юм. Бусдын зовлонг үүрч, хүн төрөлхтний үйлдсэн нүгэл хилэнц, гэм буруугийн төлөөсийг өөрийн бие буюу амь насаараа үүрсэн Есүсийн домог, Библи судрын гол утга учир, дэвшүүлсэн асуудал нь энэхүү зохиолын далд хүүрнэлийн дуу хоолой гэдгийг зөв ойлгож ухамсарлах нь суралцахуйн чухал зорилтын нэг юм.</p>	
<p>11.16. Зохиолын сэдэв, утга санаа, хам сэдвийн холбоо хамаарлыг тайлбарлах, далд утгыг тайлан тайлбарлах</p>	<p>А. Сэдэв, утга санааг, хэм сэдвийн холбоо хамаарлыг тайлбарлахдаа: – Хувь хүний эрх чөлөө нэн ялангуяа чөлөөт сэтгэлгээ буюу уран бүтээлийн эрх чөлөөний асуудал энэ зохиолын үндсэн сэдэв юм. Харин тухайн цаг үе буюу 1970-аад оны үеийн ЗХУ-ын /өнөөгийн ОХУ/ нийгмийн байгууламж болох социализмын гүн хямрал, бэртэгчин бурангуй үзэл суртал зэргийг шог элэглэлийн аргаар хэтрүүлэгтэйгээр шүүмжилсэн явдал энэ зохиолын хам сэдэв болно. Энэхүү нийгэм үзэл суртлын дампуурал доголдлыг шүүмжилсэн шүүмжлэл хувь хүний амьдрал хувь заяаны эргүүлгэнд хэрхэн нөлөөлсөнийг хошин шог хэлбэрээр дүрсэлсэн нь утга агуулга болоод илэрхийлж буй хэлбэр хоорондын ер бусын сонирхолтой, уран гоё зохицлыг бий болгож дахин давтагдашгүй үгийн урлагийн нэгийг төрүүлсэн байна. Чухам энэ зохицол найрслыг /гармония/ сэдэв утгын нэгдэл буюу өнөөгийн бидний шилжүүлэн мэдэмхийрээд байгаагаар бол хам сэдвийн холбоо хамаарал гэж тайлбарлаад байна. Энэ бүхнийг зохиолынхоо агуулга, үйл явдлаар дамжуулан ойлгож ухамсарлах, тайлбарлах, өөрийн бодол сэтгэгдлээ илэрхийлж сурах нь суралцагчдын суралцахуйн зорилтын нэг чухал удирдамж мөн.</p> <p>Б. Далд утгыг тайлан тайлбарлахдаа: – Социализмын хаалттай, үзэл суртлын хатуу чанд цензур тогтоосон байсан 1970-аад онд нийгэм цаг үеэ шүүмжилсэн шүүмжлэл нь энэ зохиолын далд утга юм.</p>	
<p>11.1в. Зохиомжийн бүрэлдэхүүн хэсгүүдийг таньж, утга санаанд хэрхэн нөлөөлж байгааг тайлбарлах</p>	<p>А. Зохиомжийн бүрэлдэхүүн хэсгүүдийг тодруулахдаа: – Хүүрнэл, тодорхойлол, хөрөг дүрийн арга, харилцан яриа, байгалын зураглал, ганцаарчилсан яриа, сэтгэлийн өчиг, зохиогчийн тэмдэглэл зэрэг зохиомжийн олон янзын хэв маягийг хооронд нь сүлэлдүүлэн ашигласан нь зохиолын ил ба далд утга санаа, дэвшүүлсэн асуудлыг тодруулахад нийцэж зохицсон уран чадварлаг зохиомж болж чадсаныг ойлгож ухамсарлах танин барих нь суралцахуйн нэг зорилт байна. Жишээ нь : зохиолд буй сахиусан тэнгэрүүд болон согтуу Веня хоёрын хоорондын яриаг согтуу хүний мансуурал донтолт байдлаар дүрслэн бичсэн нь уншигчдад дамжуулах гэсэн зохиогчийн санааг маш их сонирхолтой, итгэл үнэмшил төрүүлэхүйц уран яруу болгож чадсан байдаг.</p> <p>Б. Зохиомжийн онцлог нь зохиолын утга санаанд хэрхэн нөлөөлж байгааг тайлбарлахдаа: -- Хүүрнэл, “би” баатрын 1-р биенээс хүүрнэн өгүүлсэн дотоод сэтгэлийн өчиг хэлбэрээр бичигдсэн энэ зохиол нь хэдийгээр үргэлжилсэн үгийн туульсын хэлбэрээр бичигдсэн боловч түүнийг уянгын яруу найргийн төрөл зүйлд хамааруулах гол үндэслэл болдог. Энэ бол “Москва – Петушки” зохиолын зохиомжийн үндсэн онцлог юм.</p>	

<p>11.1г. Зохиолын Дүрийн бодгаль ба нийтлэг шинжийг тодорхойлж, зохиолын утга санаанд хэрхэн нөлөөлж буйг тайлбарлах</p>	<p>А. Дүрийн бодгаль ба нийтлэг шинжийг тодорхойлохдоо -- гол дүр Веня нь үнэн хэрэгтээ зохиогч В.Ерофеевын өөрийнх нь дүр юм. Веня нэг талаасаа амьдралаа алдсан гудамжны архичин, манайхны хэлдэгээр “өвгөнтийн хөндийнхөн” боловч нөгөө талаараа тухайн цаг үеийн төдийгүй өнөөдөр ч олон буй ажил амьдралгүй, бүтэл зэхий амьдралаасаа болж архинд донтсон хүмүүсийн нийтлэг төлөөлөл болсон дүр юм. Нэг талаасаа Веня гэдэг нэртэй, эхнэрээсээ салсан, урлаг уран зохиолын өндөр мэдлэгтэй, хоёр гадаад хэл эзэмшсэн, Москва хотын Петушки өртөөнд амьдардаг хүүхэдтэй эмэгтэйд сэтгэл алдарсан ядарч яваа 36 настай жирийн нэг Орос эрийн давтагдашгүй бодгаль дүр харин нөгөө талаасаа хүнд сурталтай, явцуу үзэл сурталдаа баригдсан бурангуй нийгмийнхээ буруугаас болж хохирсон мянга мянган авьяас билигтэй, өндөр боловсролтой, ажилчин, сэхээтэн хүмүүсийн нийтлэгийн төлөөлөл дүр юм. Чухам энэ нь зохиолын дэвшүүлж буй үндсэн утга санаа болох нийгмээ шүүмжилсэн хурц шүүмжлэлийг нөхцөлдүүлж байгааг ойлгож ухамсарлах явдал суралцахуйн гол зорилтын нэг мөн.</p> <p>Б. Дүрийн шинж нь зохиолын сэдэв, утга санаанд хэрхэн нөлөөлж буйг тайлбарлахдаа: -- Гол дүр нь гудамжны архичин, мансууралд гүн нэрвэгдсэн, архины хөнгөн хэлбэрийн цагаан солиоролд орсон хүн байдаг нь “Москва – Петушки” зохиолын шүүмжлэлт сэдэв, нийгмийнхээ тогтолцоог эсэргүүцсэн утга, үзэл санааг маш хурц тод, сонирхолтой болгож өгдөг.</p>	
<p>11.1д Зохиолын гадаад, дотоод орчин нь дүрийг тодруулахад хэрхэн нөлөөлж буйг тодорхойлох</p>	<p>А. Зохиолын гадаад ба дотоод орчныг тайлбарлан дүгнэхдээ -- 1970-аад озы Орос орны нийгэм түүхийн онцлог, социалист үзэл санааны хатуу чанд мөрдлөг хавчилт, зохиолч В.Ерофеевын амьдрал хувь заяа, эмгэнэлт хувь тавилан, тэр цагийн үзэл суртал, социалист реализмын урлаг уран зохиол зэрэг нь “Москва – Петушки” зохиолын гадаад орчин бөгөөд чуха энэ л гадаад нөхцөл байдлууд энэхүү зохиолын дотоод агуулга буюу шүүмжлэлт үзэл санааг нахцелдүүлж өгсөн юм шүү дээ. Чухам зохиол бичигдэж байх үеийн энэ бүх гадаад орчин нөхцөл нь романы гол дүр Веня буюу зохиолч В.Ерофеевын амьдрал хувь заяаг бий болгосон түүхтэй. Чухам үүнийг л сайтар ойлгох нь нэн чухал.</p> <p>Б. Зохиолын гадаад ба дотоод орчин нь дүрийг тодруулахад хэрхэн нөлөөлж байгааг ярилцахдаа – Дээр нэгэнт тайлбарлачихлаа !</p>	
<p>11.1е. Зохиолын найруулга нь утга санаанд хэрхэн нөлөөлж буйг тодорхойлох</p>	<p>Зохиолын найруулгыг судлахдаа: – “Москва – Петушки” зохиол нь хошин шог өнгө аястай элэглэлийн хэлбэрээр бичигдсэн инээдмийн хэв маяг бүхий уран хэтрүүлэг, егөөдөл зэргийг ихээхэн ашигласан хэл найруулгын онцлогтой бүтээл. Энэ зохиолын найруулга нь дээр нэгэнтээ дурдсанаар хүүрнэл болон уянгын “би” баатрын дотоод сэтгэлийн өчиг хэлбэрээр бичигдсэн хөнгөн хэлбэрийн найруулгатай. Нөгөө талаараа гудамжны үг хэллэг буюу хар ярианы үг, мэргэжлийн жаргон, зэргийг ихээхэн ашигласан. Хар ярианы хэлийг найруулгын дээд төрлийн хэлбэртэй хольж сүлэлдүүлсэн онцлог бас бий. Жишээ нь : Библи судрын ариун номлол гэх мэт судрын эрхэмсэг дээд найруулгыг гудамжны архичдын хар ярианы бүдүүлэг үг хэллэгтэй хольж сүлэлдүүлсэн интертекстийн</p>	

	<p>аргыг хэрэглэсэн. Ер нь интертекстийн арга нь модернизм болон постмодернизмын утга зохиолын хэл найруулгын үндсэн хэв маяг болдогийг “Москва – Петушки” зохиолыг уншиж судлахдаа суралцагчид өөрсдийн суралцахуйн үндсэн зорилтын нэг болговол зохино.</p>	
<p>11.1г. Шүүмжийн санаа, шүүмжлэгчийн үнэлгээ, дүгнэлтийг тайлбарлах</p>	<p>А. Утга шилжүүлэн дүрсэлсэн үг хэллэгийг таних, үндсэн утгаас шилжсэн ямар утга гарч байгааг ажиглах - “...Ай хөөрхий, цаг зуурын бэрхшээл ээ! Ээ, миний ард түмний амьдрал дахь хамгийн хүнд, хүч тамираа барсан, хамгийн шившигтэй муухай үе үүр цайхаас дэлгүүр онгойх хүртэлх цаг! Орон гэргүй, уйтгарлаж шаналдаг маань үнэн ч сайхан элгэн хүрэн үстэй бидний толгойд энэ цаг үе хичнээн олон хэрэггүй буурал үс нэмнэ вэ!...” хэмээх энэ үг нь нэг талаасаа архинд орсон гол дүр Венягийн шар тайлах хүслийг илэрхийлж буй боловч цаад утгаараа аугаа их Орос орны нийгмийн амьдралыг бүхэлд нь шүүмжилсэн гүн гүнзгий зүйрлэл санааг агуулж байгаа билээ. Ийм утга шилжүүлсэн зүйрлэл буюу далд утга энэ зохиолд маш их байдаг. Энэ нь ч энэ зохиолын уран сайхны аргыг сюрреализм гэж тодорхойлоход хүргэж байдаг юмаа.</p> <p>Б. Зохиолын хэл яриаг илүү үр дүнтэй болгохын тулд хэрэглэсэн уран дүрслэл ба яруу хэрэглүүрийн хэрэглээг шинжлэх</p> <p>- “...Энэ бол та бүхний дуулгавартай зарц, бригадын дарга асан, Москва-Петушки найраглалын зохиогчийн шугам дурайж байна даа.</p> <p>Сонирхолтой зурааснууд байгаа биз. Зөвхөн дээд үзүүрийг харахад л сонирхол татаж байна, тийм үү? Заримынх нь Гималай, Тироль, Бакинскийн санаа бодол, бүр миний хэзээ ч хараагүй Кремлийн хана шиг байна...”</p> <p>Хаана, юу уугаа вэ? Ингэлээ гээд ямар үр дүн гарав? Таашаал эдлэх гэж уусан болж байна уу, хор хохирол учруулах гэж уув уу?</p> <p>Ёстой бүү мэд дээ, үүнийг одоо яагаад ч мэдэшгүй. Хаан Борис ханхүү Димитрийг алсан уу, эсвэл эсрэгээр болсон уу гэдгийг бид одоо болтол мэддэггүйтэй л адил гээд ойлгочиход болно...”</p> <p>В. Бичил дүрслэлийн хэрэглээг тайлбарлах - “...Бүгд л Кремль, Кремль гэгцгээх юм. Бүх хүнээс түүний тухай сонсдог авч өөрөө би ганц ч удаа үзээгүй. Согтуу хөлчүү, шартаж мангартан ер хичнээн удаа /лав мянга хүрсэн биз/ Москвагаар хөндлөн гулд, баруунаас зүүн тийш, умардаас өмнө тийш, нэг захаас нь нөгөө зах хүртэл явав даа. Тэгэхдээ Кремлийг л ганц ч удаа олж харсангүй...” Энэ бол архичин хүний зүгээр л нэг солиорол яриа мэт боловч 1960-70-аад оны өнөө “зогсонги цаг үе” гэгчийг л шүүмжилж байгаа уран хэтрүүлэг төдий юм шүү дээ. Тэр үед улс орны удирдагчид хаана байгаа, юу харж байгаа? Улс орныг ямар дампууралд оруулсан бэ? гэдгийг ЗХУ 1991 онд бутран унахаас даруй 30 жилийн өмнө суут зохиолч В.Ерофеев ингэж егөөдөн бичиж байжээ.</p> <p>Чухам ийм олон арван бичил дүр дүрслэл, ёгт санаа, уран хэтрүүлэг, элэглэл шүүмж зэргийн цаад далд утга санааг ойлгож ухамсарлах нь суралцагчдын суралцахуйн чухал зорилтуудын нэг болно.</p>	

Хятадын уран зохиол: Романыг уншиж судлах

Суралцахуйн зорилт	Үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p>11.1а. Хятадын сонгодог романаас монгол орчуулгаар уншиж, хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэх</p>	<p>А. Хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэхдээ: - Хятадын Мин улсын үеийн соёл, аж амьдралын хэвшил, ертөнцийг үзэх үзлийг ойлгох – Зохиолын Газарзүй, Этнографийн ач холбогдол – Тансан ламын туулсан Дундад Ази, Торгоны замын байдал – Б. Үзэл бодлоо илэрхийлэхдээ: – Суурьшмал соёл иргэншлийн онцлогийг нүүдлийн соёл иргэншил, өөрийн орны ахуй соёлтой харьцуулан илэрхийлэх</p>	<p>Тансан лам баруун этгээдэд зорчсон тэмдэглэл, Зян Рун “Чонон сүлд”</p>
<p>11.1б. Хүүрнэлийн учир холбогдлыг тодорхойлж, дуу хоолойг тайлбарлах</p>	<p>А. Хүүрнэлийн учир холбогдлыг тодорхойлохдоо: – Зохиолын романтик ба фантастик, ид шидийн учир холбоос дүрслэлүүд – Туульслаг шинж Б. Дуу хоолойг тайлбарлахдаа: – Уран санаа, Шидэт үлгэрийн байдал</p>	
<p>11.1б. Зохиолын сэдэв, утга санаа, хам сэдвийн холбоо хамаарлыг тайлбарлах, далд утгыг тайлан тайлбарлах</p>	<p>А. Сэдэв, утга санааг, хэм сэдвийн холбоо хамаарлыг тайлбарлахдаа: – Сүн Ү Күн сармагчны хаан “Сайхан бичин ван” болоод жаргалтай сайхан байсан боловч үүндээ сэтгэл ханалгүй мэнхрэх эрдэм сурахаар явдаг нь түүний эрэлч сэтгэлийг илэрхийлнэ. Үүгээрээ Фаустийн санаатай төстэй. – 629-645 онд Тан улсын Шюань Зан ламын Энэтхэг рүү Бурхан шашны ном залахаар хийсэн аяллын түүх дээр үндэслэн Фантастик роман зохиосон нь. Б. Далд утгыг тайлан тайлбарлахдаа: – Мин улсын тухайн үеийн нийгмийн байдлыг шоглон дүрсэлсэн – Сүн Ү Күн тэнгэрийн орныг самууруулсан явдал нь хэдийгээр тэнгэрийн орон түүний хувилгаадтай тэмцсэн мэт боловч жинхэнэдээ эрх баригчидтай, ночрхогч ангитай тэмцэл хийсэн явдал юм. – Сүн Ү Зүний гадаад байдал нь муухай гэж олон удаа гадуурхагддаг нь харц гаралтай гэсэн санаа байж болох, ид шидтэй боловч энэ нь гол биш арга ухаантай шударга хүний дүрийг илтгэсэн.</p>	
<p>11.1в. Зохиомжийн бүрэлдэхүүн хэсгүүдийг таньж, утга санаанд хэрхэн нөлөөлж байгааг тайлбарлах</p>	<p>А. Зохиомжийн бүрэлдэхүүн хэсгүүдийг тодруулахдаа: – Өгүүлэлт зохиолын \бүлэглэлт роман\ зохиомжийн онцлог – Романтик, Фантастик аргыг хэрэглэж сонин гайхамшигтайгаар сэтгэж урласнаар өнөөг хүртэй уншигчдад хүрч чадсан болох Б. Зохиомжийн онцлог нь зохиолын утга санаанд хэрхэн нөлөөлж байгааг тайлбарлахдаа: – Шүлэг хүүрнэл хослуулсан, шог хэллэг, бэлэгдэл тэр дундаа өнгө, тооны бэлэгдлийн дүрслэл ихтэй байдаг. Сүн Ү Күн 72, Гахай багш, Шороо багш хоёр 36 янз хувирдаг, зохиолд 81 шалтаг гардаг гэх мэт.</p>	

<p>11.1г. Зохиолын дүрийн бодгаль ба нийтлэг шинжийг тодорхойлж, зохиолын утга санаанд хэрхэн нөлөөлж буйг тайлбарлах</p>	<p>А. Дүрийн бодгаль ба нийтлэг шинжийг тодорхойлохдоо – Тансан ламын дүрээр Шашны номлол болон бодит амьдрал хоёрын зөрчлийг тусгасан нь – Сүн Ү Күний дүрийн ардач шинж, түүний ялагдашгүй хүчин чадал ба хөгжилтэй дүрсгүй байдал – Гахай багшийн дүрээр хүний бодгаль чанаруудыг тодорхойлсон нь</p> <p>Б. Дүрийн шинж нь зохиолын сэдэв, утга санаанд хэрхэн нөлөөлж буйг тайлбарлахдаа: – Зохиолд нэг талаас шашны нот залахаар яваа тойн хүмүүсийг дүрсэлсэн боловч нөгөө талаар лам нарын амьдралаас тасархай шинжийг дүрсэлсэн. \ганцаараа явж чадахгүй, амьдрах арга ухаан муу гэх мэт\ – Нийгмийг шүүмжлэгч баатарлаг тэмцэгчдийн дүрийг бүтээсэн нь – Сүн Ү Күний хурц ухаан, шогч байдал</p>	
<p>11.1д. Зохиолын гадаад, дотоод орчин нь дүрийг тодруулахад хэрхэн нөлөөлж буйг тодорхойлох</p>	<p>А. Зохиолын гадаад ба дотоод орчныг тайлбарлан дүгнэхдээ - Зохиолын бодит амьдрал ба амьдралд байдаггүй хийсвэр зүйлсийг тодруулах Б. Зохиолын гадаад ба дотоод орчин нь дүрийг тодруулахад хэрхэн нөлөөлж байгааг ярилцахдаа – Тамын орон, Тэнгэрийн орон, Лусын орон, Хурмастын хаан, элдэв шулмасууд, Лусын хаан, Тамын эзэд, Элдэв бурхад зэрэг маш олон хийсвэр дүрүүд ертөнцийн хүмүүстай адил дүрслэгдсэн</p>	
<p>11.1е. Зохиолын найруулга нь утга санаанд хэрхэн нөлөөлж буйг тодорхойлох</p>	<p>Зохиолын найруулгыг судлахдаа: – Төв үзэл ба сүвэгч орхих аргыг тухайн зохиолд түлхүү ашигласан байдал – Үйл явдлууд нь нэг ерөнхий загвартайг анхаарах \Шулмасыг дарж чадахгүй болмогц бодисадаас тусламж авч дардаг гэх мэт. \</p>	
<p>11.1г. Шүүмжийн санаа, шүүмжлэгчийн үнэлгээ, дүгнэлтийг тайлбарлах</p>	<p>А. Утга шилжүүлэн дүрсэлсэн үг хэллэгийг таних, үндсэн утгаас шилжсэн ямар утга гарч байгааг ажиглах Б. Зохиолын хэл яриаг илүү үр дүнтэй болгохын тулд хэрэглэсэн уран дүрслэл ба яруу хэрэглүүрийн хэрэглээг шинжлэх -Гахай багшийн хэл ярианы эгэл борогжуун, инээдэмтэй байдал \эм шуламсууд эр эм болое гэхэд гахай л ганцаараа зөвшөөрч байгаа, мөн жирэмсэн болж байгаа зэрэг\ В. Бичил дүрслэлийн хэрэглээг тайлбарлах -Тамд хүртэл арын хаалга байдаг гэж дүрсэлсэн нь нийгмийн шүүмжлэлт санааг нь гүнзгийрүүлсэн Гахай багшийн бүдүүлэгдүү, хүүхэмсэг зан тухайн зохиолын чимэг, уншигчдыг татах шигтгээ болж өгсөн</p>	

Японы уран зохиол

Суралцахуйн зорилт	Үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p>11.1а. Японы сонгодог жүжиг, тууж,</p>	<p>А. Хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэхдээ: – 1868 оны Шёгуны засаглалыг унагасан хувьсгалын үрээр Мейжийн шинэчлэл хийгдэж улс тар нийгмийн шинэ шатанд гарсан нь тухайн зохиолд хэрхэн илэрсэн байгааг тодорхойлох – Мурасаки Сикибу “Генжийн туульс”-ийг дэлхийн анхны роман гэх учир</p>	<p>\ Мурасаки Сикибу “Генжийн туульс”, Агутаговагийн өгүүллэгүүдээс 4. Акутагава Рюноске.</p>

<p>романаас монгол орчуулгаар уншиж, хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэх</p>	<p>–Р. Акутагава “Хамар ” өгүүллэгийг Японы шашин шүтлэгтэй холбон ойлгох Б. Үзэл бодлоо илэрхийлэхдээ: –Тухайн үеийн Японы түүх, уран сайхантай холбоотой суурь мэдлэгтээ тулгуурлан зохиолын орчин той холбон илэрхийлэх \Самуурай, \</p>	<p>Хайраас бусад нь юу ч биш. Орчуулсан Д.Цоодол. УБ таймс СХУ., 2006</p>
<p>11.1б. Хүүрнэлийн учир холбогдлыг тодорхойлж, дуу хоолойг тайлбарлах</p>	<p>А. Хүүрнэлийн учир холбогдлыг тодорхойлох Б. Дуу хоолойг тайлбарлахдаа:</p>	
<p>11.1б. Зохиолын сэдэв, утга санаа, хам сэдвийн холбоо хамаарлыг тайлбарлах, далд утгыг тайлан тайлбарлах</p>	<p>А. Сэдэв, утга санааг, хэм сэдвийн холбоо хамаарлыг тайлбарлахдаа: –Р. Акутагава “Хамар ” өгүүллэгт тусгагдсан хүний өөртөө итгэлгүй байх, өөрийгөө чамлах байдал нв өнөөдрийн нийгэмд ямар хэлбэрээр хэрхэн илэрч байгааг тодруулах –Б. Далд утгыг тайлан тайлбарлахдаа: – Агь Гензийн зугаа цэнгэлээр дүүрэн амьдралаар тухайн үеийн язгууртны амьдралыг илрүүлэн гаргах</p>	
<p>11.1в. Зохиомжийн бүрэлдэхүүн хэсгүүдийг таньж, утга санаанд хэрхэн нөлөөлж байгааг тайлбарлах</p>	<p>А. Зохиомжийн бүрэлдэхүүн хэсгүүдийг тодруулахдаа: “Төгсгөлийн үзэл санааг ойлгох Б.Зохиомжийн онцлог нь зохиолын утга санаанд хэрхэн нөлөөлж байгааг тайлбарлах</p>	
<p>11.1г. Зохиолын дүрийн бодгаль ба нийтлэг шинжийг тодорхойлж, зохиолын утга санаанд хэрхэн нөлөөлж буйг тайлбарлах</p>	<p>А. Дүрийн бодгаль ба нийтлэг шинжийг тодорхойлох –Зохиолд гарах 300-аад дүрийн хэв шинж, онцлогийг гаргах Р. Акутагава “Хамар ” өгүүллэгийн Зэнти ламын дүр эмгэнэлт дүр үү, инээдмийн дүр үү гэдгийг эргэцүүлэх Б. Дүрийн шинж нь зохиолын сэдэв, утга санаанд хэрхэн нөлөөлж буйг тайлбарлах -</p>	
<p>11.1д Зохиолын гадаад, дотоод орчин нь дүрийг тодруулахад хэрхэн нөлөөлж буйг тодорхойлох</p>	<p>А. Зохиолын гадаад ба дзотоод орчныг тайлбарлан дүгнэх Б. Зохиолын гадаад ба дотоод орчин нь дүрийг тодруулахад хэрхэн нөлөөлж байгааг ярилцах</p>	
<p>11.1е</p>	<p>Зохиолын найруулгыг судлах</p>	

<p>Зохиолын найруулга нь утга санаанд хэрхэн нөлөөлж буйг тодорхойлох</p>		
<p>11.1г. Шүүмжийн санаа, шүүмжлэгчийн үнэлгээ, дүгнэлтийг тайлбарлах</p>	<p>А. Утга шилжүүлэн дүрсэлсэн үг хэллэгийг таних, үндсэн утгаас шилжсэн ямар утга гарч байгааг ажиглах Б. Зохиолын хэл яриаг илүү үр дүнтэй болгохын тулд хэрэглэсэн уран дүрслэл ба яруу хэрэглүүрийн хэрэглээг шинжлэх</p> <p>В. Бичил дүрслэлийн хэрэглээг тайлбарлах - Р. Акутагава “Хамар ” өгүүллэгийн Зэнтэ лам буцаад том хамартай болохдоо баярлаж буй хэсэг</p>	